

## ГАРЧИГ

- 2–5 Бодлогын нийтлэл
- 6–8 Зохицуулалтын мэдээ
- 9–10 Ярилцлага
- 11–12 Тогтвортой санхүүжилт
- 13 Компанийн засаглал, комплайнс
- 14–15 Финтек ба регтек
- 16–23 Судлаачийн индэр
- 24–25 Санхүүгийн салбар дах хиймэл оюун ухааны хэрэглээ
- 26–27 Олон улсын зах зээлийн мэдээ
- 28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## НИЙГМИЙН БОЛОН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН БОНД ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЛЭЭ

Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн



**Танд энэ өдрийн мэнд хүргэе. Сүүлийн жилүүдэд манай улсын хөрөнгийн зах зээл өндөр өсөлттэй гарч, зах зээлд оролцогчдын идэвх оролцоо хурдацтайгаар нэмэгдэж байна. Энэхүү хөрөнгийн зах зээлд зэрэг өөрчлөлтийг авчирсан бодлого, зохицуулалтын томоохон ажлуудын заримаас нь онцлохгүй юу?**

Өдрийн мэнд хүргэе. Сүүлийн жилүүдэд манай улсын хөрөнгийн зах зээл хурдацтай өсөж, хөгжлийн түвшин, цар хүрээ нь өргөжин тэлж байгааг олон төрлийн тоон үзүүлэлтүүд тодорхой харуулж байна. Энэхүү өсөлт, ахиц дэвшлийг бий болгоход Санхүүгийн зохицуулах хороо үнэт цаас гаргагчид болон мэргэжлийн байгууллагуудтай нягт хамтран ажилласан нь чухал үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж байна. Үүний зэрэгцээ Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ, хууль эрх зүйн орчны шинэчлэлүүд нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, зах зээлийн тогтвортой өсөлтийг дэмжсэн онцлох хүчин зүйл болсон юм.

Тухайлбал, өнгөрсөн оны тавдугаар сард Улсын Их Хурлаас Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан нь хөрөнгийн зах зээлд олон улсын жишигт нийцсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг нэвтрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн чухал алхам болсон. Энэ нь дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг нэмэгдүүлж, санхүүгийн зах зээл дэх мөнгөн урсгалыг өргөжүүлэх, хувийн хэвшлийн компаниуд урт хугацаат санхүүжилт татах үйл явцыг хөнгөвчлөх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Тус хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр олон улсын санхүүгийн байгууллагууд Монгол Улсын бондын зах зээлд өрийн хэрэгсэл гаргах боломжтой болсон нь хөрөнгийн зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн нэмэгдэхээс гадна Засгийн газрын үнэт цаастай адил эрсдэл багатай санхүүгийн хэрэгсэл бий болж, бондын зах зээл олон улсын жишгээр хөгжих нөхцөлийг бүрдүүлж буй чухал зохицуулалт болсон.

Түүнчлэн, онцлох өөр нэгэн зохицуулалт нь гарааны болон жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог хангах, бизнесийн орчныг дэмжих, харьцангуй найдвартай, хямд санхүүжилтийн эх үүсвэрийг платформуор дамжуулан татах боломжийг нээж өгөх үүднээс технологид суурилсан, шинэ санхүүгийн үйлчилгээ болох хувьцааны хамтын санхүүжилтийн эрх зүйн орчныг бүрдүүлсэн явдал юм.

Мөн мөнгөний захын санхүүгийн хэрэгсэл болох хадгаламжийн сертификатыг хөрөнгийн зах зээлд нэвтрүүлж, банкны салбарын хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг нэмэгдүүлснийг дурдах нь зүйтэй болов уу. Ингэснээр хөрөнгийн зах зээл дээр арилжаалагддаг, хөрвөх чадвар сайтай хадгаламжийн сертификат бий болж, банкны салбараас эх үүсвэр татах эрсдэл багасах, иргэд, хадгаламж эзэмшигчид цаг хугацаа, орон зайнаас үл хамааран банкаа сонгох, хадгаламжаа хоёрдогч зах дээр арилжаалах боломжтой болж байна.

Үргэлжлэлийг 7-р нүүрт



## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

### Даатгалын гэрээ

Contract of Insurance/

Даатгагч нь даатгалын тохиолдол бий болоход даатгуулагчид учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгалын хураамж төлөх үүргийг хүлээсэн хэлцэл. Даатгалын зүйл нь эд хөрөнгө, иргэдийн амь нас, эрүүл мэнд, түүнчлэн хуульд харшлаагүй эдийн бус ашиг сонирхол байна. Даатгал нь сайн дурын болон албан журмын гэсэн төрөлтэй байна. Албан журмын даатгалын хэлбэрийг хуулиар тогтооно. Холбогдох хууль– Иргэний хууль, Даатгалын тухай хуулиуд.



### Бенефит гэрээ

Benefit policies

Урьдчилан таамаглаагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тодорхой хэмжээний нөхөн төлбөр олгох даатгалын гэрээ. Гэнэтийн ослын болон өвчний эрсдэлийг даатгасан гэрээнүүд энэ төрөлд багтах ба ийм гэрээнд нөхөн төлбөрийн зарчим үйлчлэхгүй. Тухайлбал, даатгуулагч эрхтэн дутуу болсон тохиолдолд санхүүгийн нөхөн олговроор тухайн эрхтнийг бүрэн сэргээх боломжгүй юм

*Эх сурвалж: Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь 2024 он*

## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### 2025 ОНЫ БАЙДЛААРХ ФАТФ–ЫН ЗӨВЛӨМЖ 15–ЫН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ, СУЛ ТАЛУУД БА ШИНЭ ЭРСДЭЛҮҮД


Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (цаашид “ФАТФ” гэх) нь дэлхийн санхүүгийн системийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх (цаашид “МУТС/ҮОХЗДС” гэх) гэмт хэрэгт ашиглагдахаас хамгаалах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий улс хоорондын хараат бус эрх бүхий байгууллага юм. Энэ хүрээнд тус байгууллага нь МУТСТ чиглэлээр олон улсын стандарт тогтоож, улс орнуудын үндэсний хууль тогтоомж, зохицуулалтыг бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. Нийтдээ глобал сүлжээний 200 гаруй улс орон ФАТФ–ын стандартыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн. ФАТФ–аас улс орнуудын МУТС/ҮОХЗДС–тэй тэмцэх тогтолцоо, хариу арга хэмжээний чадавхыг үнэлэх хүрээнд Техникийн 40 Зөвлөмж, Үр дүнтэй байдлын 11 Шууд хэрэгжилт гэсэн 2 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийж гүйцэтгэхийн сацуу улс орнуудын МУТСТ арга хэмжээний харилцан үнэлгээг хийж гүйцэтгэдэг.

ФАТФ–аас 2018 оны 10 дугаар сард виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (цаашид “ВХҮҮ” гэх)–ийн ойлголт, эрсдэлд суурилсан аргачлалыг тодорхойлох үүднээс ‘шинэ технологи’ буюу Зөвлөмж 15–ыг шинэчилсэн. Тус зөвлөмжийн шинэчилсэн найруулгад улс орнууд виртуал хөрөнгөөс үүсэж болзошгүй эрсдэлийг удирдах, бууруулах, ВХҮҮ–үүдийг МУТСТ зорилгоор хууль эрх зүйн зохицуулалтад хамруулах, бүртгэх эсвэл тусгай зөвшөөрөл олгох, мөн ФАТФ–ын зөвлөмжид заасан хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийг тусгасан. 2019 оны 06 дугаар сард ФАТФ–аас Зөвлөмж 15–д нэмэлт өөрчлөлт оруулж, виртуал хөрөнгөтэй холбоотой тодорхойлолт, ВХҮҮ–дэд тавигдах шаардлагуудыг илүү нарийвчлан тодорхойлсон.

Үүнтэй уялдуулан, ФАТФ нь 2025 оны 06 дугаар сард Зөвлөмж 15 ба түүний хэрэгжилтийн талаарх зургаа дахь тайланг шинэчлэн гаргасан байна. Энэхүү тайлан нь 2025 оны 04 дүгээр сарын байдлаар дэлхий дахины нөхцөл байдлыг харуулж, улс орнуудын ФАТФ–ын Зөвлөмж 15–ын хэрэгжилтэд гарсан ахиц дэвшил болон шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг онцолсон байна.

### Хууль эрх зүйн орчин дахь ахиц дэвшил ба дутагдал

Хүснэгт. Зөвлөмж 15–ын хэрэгжилт (2025 оны 04 дүгээр сарын байдлаар)




Эх сурвалж: 2025 оны ФАТФ–ын Зөвлөмж 15–ын хэрэгжилтийн тайлан

2025 оны байдлаар ФАТФ–ын үнэлгээнд улс орнуудын 29 хувь нь Зөвлөмж 15–ын техник хэрэгжилтийг “дийлэнх нь биелсэн” буюу түүнээс дээш үнэлгээ авсан нь 2024 оныхоос 4 хувиар ахисан үзүүлэлт юм. Энэ нь МУТСТ хүрээнд улс орнууд өөрсдийн хууль эрх зүйн орчинд ВХ болон ВХҮҮ–тэй холбоотой зохицуулалтыг тусгаж, сайжруулсныг харуулж байна. Тухайлбал, улс орнууд ВХҮҮ–дийг бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг тайлагнах үүрэгтэй болгох, МУТСТ шаардлагыг мөрдүүлэх зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

Гэсэн хэдий ч Зөвлөмж 15–ын хэрэгжилт 2025 оны байдлаар улс орнуудын 21 хувь нь хангалтгүй үнэлгээтэй хэвээр байгаагаас үзэхэд зарим улсуудад хууль эрх зүйн хүрээнд сул тал байсаар байгаа бөгөөд энэ нь санхүүгийн гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхэд ашиглагдах эрсдэлтэй байсаар байна.

### Эрсдэлийн үнэлгээ ба эрсдэлд суурилсан аргачлал

Хүснэгт. ВХ болон ВХҮҮ–ийн салбарт МУТС эрсдэлийн үнэлгээ хийсэн улс орнуудын судалгаа



Эх сурвалж: 2025 оны ФАТФ–ын Зөвлөмж 15–ын хэрэгжилтийн тайлан

Тайлангаас үзэхэд улс орнуудын 76 хувь нь ВХ болон ВХҮҮ–ийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэсэн нь 2024 онтой харьцуулахад 5 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. Эрсдэлийн үнэлгээ буюу ФАТФ–ын Зөвлөмж 1 нь тухайн салбарын эрсдэлийг ойлгох, эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодлогыг тодорхойлоход чухал ач холбогдолтой байдаг.

Хэдийгээр тодорхой ахиц гарсан ч улс орнууд ВХҮҮ–дийг хянахдаа эрсдэлд суурилсан аргачлалыг бүрэн хэрэгжүүлж, эрсдэлийг зөв тодорхойлж, түүний хяналт, хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна. Виртуал хөрөнгө, ВХҮҮ–д нь уламжлалт санхүүгийн салбартай харьцуулахад хяналт тавихад олон талын сорилт, хүндрэлийг зохицуулагч байгууллагуудад үүсгэж байгаа тул улс орнууд салбарын онцлогт нийцсэн, уян хатан, эрсдэлд суурилсан байдлаар зохицуулалтын орчныг бүрдүүлэх шаардлагатай болж байна.

#### **“Travel Rule” буюу аяллын дүрмийн хэрэгжилт, хяналт**

ФАТФ–ын Зөвлөмж 15–ийн хүрээнд аяллын дүрэм буюу ВХҮҮ–дээс харилцагч гүйлгээ хийх үед шилжүүлэгч болон хүлээн авагчийн мэдээллийг цуглуулж, хадгалах, тулган баталгаажуулсны үндсэн дээр гүйлгээ хийхийг шаарддаг. Энэхүү шаардлага нь ил тод байдлыг нэмэгдүүлж, МУТС–ээс сэргийлэх зорилготой юм. Аяллын дүрмийн тусламжтайгаар эрх бүхий байгууллагууд виртуал хөрөнгийн гүйлгээг мөрдөн шалгах, хяналт тавих боломжтой болдог. Гэвч 2025 оны байдлаар ВХҮҮ–ийн салбарын зохицуулалтыг бүрдүүлсэн улс орнуудын 73 хувь нь аяллын дүрмийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн зохицуулалтыг баталсан хэдий ч зөвхөн 41 хувь нь тус дүрмийг хэрэгжүүлж байна. Хууль эрх зүйн зохицуулалт байсан ч хяналт, хэрэгжилт сул байх тохиолдолд МУТСТ үйл ажиллагааны үр дүнг бууруулж, эрсдэлийг нэмэгдүүлдэг.

ФАТФ–ын тайланд стейблкойнууд нь виртуал хөрөнгийн хууль бус санхүүжилтийн гол суваг болж байгааг удаа дараа онцолсон байна. Стэйблкойны үндсэн шинж чанар болох үнэ цэнээр баталгаажсан байдал, хөрвөх чадвар, өргөн хэрэглээ нь гэмт этгээдүүдийн сонирхлыг ихээр татдаг байна. Түүнчлэн төвлөрсөн бус санхүүгийн платформууд нь

зохицуулалтын хяналт сул, нэрээ нууцлах боломжтой тул нэмэлт сорилтууд үүсгэдэг талаар тайланд дурдсан байна. Эдгээр аюул заналыг шийдвэрлэхийн тулд ФАТФ блокчэйн аналитик компаниуд, хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллаж, 2025–2026 онд стэйблкойн, төвлөрсөн бус санхүүгийн платформ, гадаад ВХҮҮ–үүдтэй холбоотой нэмэлт заавар, зөвлөмж гаргахаар төлөвлөжээ. 2026 онд нийтлэх тус зөвлөмж, тайланд Зөвлөмж 15–ийн хүрээнд гарсан ахиц дэвшил болон үүссэн аюул заналын өөрчлөлтийг олон улсын хэмжээнд үнэлэх юм. Олон улсад виртуал хөрөнгийн хууль эрх зүйн орчин сайжирч байгаа ч хэрэгжилт, хяналтын тогтолцоо харилцан адилгүй хэвээр байна. Виртуал хөрөнгө дэлхийн санхүүгийн системд илүү өргөн хүрээнд нэвтэрч буй энэ үед МУТС эрсдэлийг бууруулахын тулд үр дүнтэй хяналт, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь зайлшгүй шаардлага болжээ.

Монгол Улсын хувьд ФАТФ–ын Зөвлөмж 15–ын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Санхүүгийн зохицуулах хорооноос виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн салбарт зохистой эрх зүйн орчныг бүрдүүлж мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлд идэвхтэй ажиллаж байна. Үүний үр дүнд АНДМУТБ–ээс Монгол Улсыг ФАТФ–ын Зөвлөмж 15–ыг үнэлгээг ахиулж, “дийлэнх нь биелсэн” гэж үнэлүүлсэн анхны ФАТФ–ын гишүүн бус орон болсныг онцолж байсан билээ. 2025 оны 06 дугаар сарын байдлаар Монгол Улс нь АНДМУТБ–ээс Зөвлөмж 15–ын хэрэгжилтийг “дийлэнх нь биелсэн” болгож ахиулсан хоёр улсын нэг хэвээр байна.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### ИПОТЕКИЙН ДААТГАЛЫН ШИНЭЧИЛСЭН ЗОХИЦУУЛАЛТ ХЭРЭГЖИЖ ЭХЭЛНЭ



Ипотекийн даатгалын шинэчилсэн зохицуулалт энэ оны 8 дугаар сарын 01–ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхлэхтэй холбоотойгоор иргэд, олон нийтийн дунд ойлгомжгүй, төөрөгдөл үүсгэж байсан асуудлыг тодорхой болгох зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооноос урт хугацааны даатгагч болон даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхэлж байгаа арилжааны банкнуудад дараах арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болголоо. Үүнд:

- ◆ Ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын үндсэн эрсдэлийн хүрээнд эрсдэл учрах шалтгаан, нөхцөлийг зээлдэгч, даатгуулагч нар сайн дураар, чөлөөтэй сонгох боломжийг бүрдүүлэх;
- ◆ 2025 оны 8 дугаар сарын 01–ний өдрөөс өмнө байгуулсан ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын гэрээний нөхцөлийг дордуулахгүй /даатгалын хураамжийг нэмэгдүүлэхгүй, бусад нөхцөлийг дордуулахгүй/–гээр даатгалын бүтээгдэхүүний сонголтыг даатгуулагчид олгох;
- ◆ 2025 оны 8 дугаар сарын 01–ний өдрөөс өмнө байгуулсан ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын гэрээний хугацаа дуусгавар болох хүртэл тус гэрээ хүчинтэй байх талаар даатгуулагчид мэдээлж ажиллах;
- ◆ Зээлдэгч даатгуулагч нарт уг даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөл, онцлог, ач холбогдлыг тогтмол танилцуулж ажиллах.

Ипотекийн даатгалын шинэчилсэн зохицуулалтын дагуу зээлдэгч, даатгуулагч нар учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах өөрт тохирсон даатгалын бүтээгдэхүүнийг чөлөөтэй сонгох боломжтой байна.

### “ОЛОН УЛСААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХ НЬ” САЛБАР ХУРАЛДААН БОЛЖ БАЙНА



Монголын эдийн засгийн чуулган 2025”–ын “Олон улсаас хөрөнгө оруулалт татах нь” салбар хуралдаан “Туушин” зочид буудлын “Соёмбо” танхимд болж байна.



Хуралдаанд УИХ–ын гишүүн, Шадар сайд, ХҮН намын дарга Т.Доржханд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, “Монголын хөрөнгийн бирж” ХК–ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн, Хуан Пабло Гармендиа, Ахлах шинжээч, Хөгжиж буй зах зээлийн үнэт цаас, StoneX Group Inc. Алан Чан, Өрийн хөрөнгийн зах зээл, Хонг Конг, Тайвань, Монгол, Макао болон Ази (Японоос бусад)–ийн орнуудын зээлжих зэрэглэлийн зөвлөх үйлчилгээний газрын дарга болон модератороор Capital Markets Mongolia (CMM)–ийн гүйцэтгэх захирал Э.Золбаяр нар оролцож байна.

Энэ үеэр Монгол Улсын санхүүгийн зах зээлийг олон улсад сурталчлах чиглэлд холбогдох байгууллагууд хэрхэн

ажиллаж байгаа мөн гадаадын хөрөнгө оруулагчид хэр хүлээн авч байгаа, хөрөнгө оруулалтыг татахын тулд цаашид хэрхэн анхаарч ажиллах, гадны хөрөнгө оруулалтыг татах боломжтой санхүүгийн шинэ хэрэгсэл (REITs, ETF, бонд гэх мэт)-ийг сурталчлах хүрээнд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар хэлэлцэж байна.

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОД НИЙЦСЭН АНХНЫ "ЖЕНДЭР" БОНДЫН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооноос “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсны үр дүнд ногоон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх, байгаль орчин, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн санхүүгийн шинэ бүтээгдэхүүний төрөл, тоо нэмэгдэх боломж бүрдсэн бөгөөд энэ хүрээнд ХААН Банк дотоодын зах зээлд анх удаа гаргаж буй “Жендэр” бондыг олон нийтэд нээлттэй санал болгох цан цохих ёслол боллоо.

Ёслолын ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Дөлгөөн, ХААН Банкны гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа, “Өлзий энд Ко капитал” ҮЦК ХХК-ийн гүйцэтгэх заахирал Б.Өлзийбаяр болон албаны бусад хүмүүс оролцов.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Санхүүгийн зохицуулах хороос хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, зах зээлд оролцогчдын оролцоог нэмэгдүүлэх, цаашлаад хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэх чиглэлээр бодлого зохицуулалтын олон ажлыг эрчимтэй хийж гүйцэтгэж байна. Ялангуяа байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах төсөл

арга хэмжээг хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор ногоон бондыг бүртгэх зохицуулалтын орчныг 2021 онд бүрдүүлсэн. Улмаар дотоодын зах зээлд 30 сая ам.долларын үнийн дүн бүхий анхны ногоон бондыг “ХААН Банк” ХК түүчээлэн гаргаж байсан бол өдгөө аж ахуйн нэгжүүдээс дотоодын зах зээлд нийт дүнгээр 40 сая ам.доллар болон 27 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий ногоон бондуудыг амжилттай гаргасны зэрэгцээ олон улсын зах зээлд мөн адил ногоон, нийгмийн болон тогтвортой бондуудыг гаргаж 290 сая долларыг амжилттай татаад байна.

Мөн нийгмийн бондын төрлүүд болох “жендэр” бонд болон эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн тодорхой асуудлыг шийдвэрлэх төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилготой бонд болон тогтвортой байдлын бондын зохицуулалтын орчныг бий болгох хүрээнд “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Ингэснээрээ ногоон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх, байгаль орчин, нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн санхүүгийн шинэ бүтээгдэхүүний төрөл, тоо нэмэгдэж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх оролцоо өсөх зэргээр дотоодын бондын зах зээлийг хөгжүүлэхэд чухал нөлөөтэй” гэдгийг онцолсон юм.

Энэ удаагийн “Жендэр” бонд нь олон улсын Sustainable Fitch байгууллагаар нийгмийн бондын зарчимтай нийцсэн дүгнэлт гаргуулсан бөгөөд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн анхны бонд гэдгээрээ онцлогтой. Түүнчлэн Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооны нийгмийн бондын зарчимд нийцсэний зэрэгцээ олон улсын байгууллагаар зээлжих зэрэглэл тогтоолгосон тул барьцаагүйгээр гаргаж байгаа бөгөөд жендэрийн тэгш байдлыг хангах, хөдөлмөр эрхлэлт, эмэгтэйчүүдийн нийгэм-эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг нийгэмд эерэг нөлөө үзүүлэхүйц төсөл хөтөлбөрүүдийг дэмжих зорилготой юм.

Энэхүү бондын хүрээнд 30 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний санхүүжилт татах бөгөөд 36 сарын хугацаатай, жилийн 16 хувийн хүүтэй, зургаан сар тутам хүү төлөгдөх нэг бүр нь 100 мянган төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 300 мянган ширхэг бондыг олон нийтэд нээлттэй санал болгосон бөгөөд цан цохих ёслолын дараа арилжаа хаагдаж, 30 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлэв.

## RE/MAX 8-Р АЗИ НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ БОЛЖ БАЙНА



Re/max 8-р Ази Номхон далайн бүсийн чуулга уулзалт Улаанбаатар хотноо энэ өдрүүдэд болж байна. Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал чуулганыг нээж хэлсэн үгэндээ “Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбар нь манай улсад хөгжөөд 20 гаруй жил, “RE/MAX” франчайзийн зохицуулалт үүсээд 10 жил болж байгаа харьцангуй залуу салбар. Энэ талаас нь үзвэл бидэнд үл хөдлөх хөрөнгийн салбар өндөр хөгжсөн бүс нутгийн улс орон, мэргэжилтнүүдээс суралцах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх олон сайн туршлагауд байгаа. Гэхдээ нөгөө талаас манай улсын үл хөдлөх хөрөнгийн салбарт өсөлт нэлээд өндөр байгаагийн зэрэгцээ хөрөнгө оруулах, хөрөнгө оруулалтын өгөөж хүртэх боломж өндөр бөгөөд үл хөдлөх хөрөнгийн салбараар дамжуулж гадаадын хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн талаарх мэдээ мэдээллийг олон улсын хөрөнгө оруулагчдад хүргэх боломж өндөр байна. Тухайлбал, өнгөрсөн оны байдлаар үл хөдлөх хөрөнгийн нийт борлуулалтын хэмжээ 2.9 их наяд төгрөг болсон бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 25 хувиар өссөн дүн юм. Санхүүгийн зохицуулах хороо үл хөдлөх хөрөнгийн салбартаа шударга, ил тод, тогтвортой зохицуулалтын орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллахын зэрэгцээ төрийн болон хувийн хэвшлийн оролцогчдынхоо санал санаачилгыг байнга сонсож, хөгжил дэвшлийн төлөө хамтран ажиллаж байна.

Ингээд өнөөдрийн чуулга уулзалтад амжилт хүсээд, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хөрөнгө оруулалтын боломж, ирээдүйн хөгжил дэвшил, техник технологи, шилдэг мэргэжилтнүүдийн ур чадвар, ноу-хауг танилцуулж, олон сайн туршлагаудын талаар харилцан бие биенээсээ суралцана гэдэгт итгэж байна” гэсэн юм.

Энэхүү чуулга уулзалтыг RE/MAX Mongolia бүс албан ёсоор зохион байгуулж байгаа бөгөөд дэлхийн 30 гаруй улсаас 300 гаруй агент, брокер эзэмшигч, салбарын

манлайлагчид, хөрөнгө оруулагчид орцож үл хөдлөх хөрөнгийн зуучлал ба брокерын мэргэжлийн хөгжил, олон улсын менежментийн шилдэг туршлага, шинэ технологийн шийдэл, зах зээлийн чиг хандлага, хөрөнгө оруулалтын орчин ба боломжуудын талаар санал солилцож, цаашдын хамтын ажлынхаа талаар ярилцаж байна.

## МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТОП-100 КОМПАНИ ТОДОРЛОО

Санхүүгийн зохицуулах хороо дотоодын томоохон компаниудыг хөрөнгийн зах зээлд бонд гаргах замаар санхүүжилт татах бололцоог нэмэгдүүлэх зорилгоор богино хугацаанд бага үнийн дүнтэй бонд гаргахад барьцаа, батлан даалт шаардахгүй байх зэргээр тавигдах шалгуурыг багасгаж, мөн арилжаа эрхлэх байгууллагад бонд бүртгүүлэх хүсэлтийг шуурхай байдлаар шийдвэрлэдэг байх бололцоог бүрдүүлсэн. Компаниудын хувьд санхүүжилтээ татдаг үндсэн зах зээл, санхүүжилтийн талбар болгон олон улсын жишгийн дагуу хөгжүүлж, нийгмийн бонд, жендэр бонд, тогтвортой хөгжлийн бонд зэрэг олон улсын чиг хандлагад нийцсэн бондын шинэ төрлийг нэмэгдүүлэх, бонд гаргахтай холбоотой санхүүжилтийн өртөг зардлыг багасгах, олон улсын байгууллагуудаас дотоодын зах зээлд төгрөгөөр бонд гаргахад бодлогоор дэмжлэг үзүүлэх зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байна.

Түүнчлэн ТОП-100 аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн эх үүсвэр татах ажиллагааг хөнгөвчлөх, бонд гаргахад тавигдах нөхцөл, шаардлагыг хялбаршуулах, зах зээл дэх засаглал, манлайллыг дэмжих, үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах, хөрөнгийн зах зээлд тэдгээрийн оролцоог өсгөх дотоодын аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлд татан оролцуулах зэргээр төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Засгийн газар, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран шалгаруулсан 2024 оны ТОП-100 аж ахуйн нэгжийн жагсаалтад Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарах нийт 15 компани багтсанаас 12 нь олон нийтэд хувьцаагаа нээлттэй арилжаалдаг ХК, 2 нь хаалттай буюу олон нийтэд хувьцаагаа арилжаалдаггүй ХК, санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 8 компани /давхардсан тоогоор/ тус тус байна. ТОП-100 ААН-ийн шалгаруулалтад багтсан нээлттэй хувьцаат компани жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм.

## ЯРИЛЦЛАГА

НИЙГМИЙН БОЛОН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН БОНД ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙ  
ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧНЫГ БҮРДҮҮЛЛЭЭ

Эхлэл нь 1-р нүүрт



*“Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн энэ удаагийн байр суурь булангаар Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн нийгмийн болон тогтвортой байдлын бонд гаргахтай холбоотой талаар ярилцлаа.*

Хорооны зүгээс томоохон аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлд татан оролцуулах зорилгоор “Топ-100” хөтөлбөрийг хэрэгжүүлж, эдгээр аж ахуйн нэгжүүдийн үнэт цаас гаргах үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээг шат дараатайгаар авч хэрэгжүүлж байна. Мөн өнгөрөгч сард нийгмийн бонд болон тогтвортой байдлын бонд гаргахтай холбоотой зохицуулалтыг бий болголоо.

Цаашлаад Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын итгэлцлийн санг /REITs/ Монгол Улсад хөгжүүлэх, зохицуулалтын орчныг бий болгох, холбогдох бодлого, дүрэм, журмыг боловсруулах хүрээнд олон улсын зохицуулалтын орчныг судалж, сайн туршлагыг хэрэгжүүлэх боломжийг судлан хуулийн төсөл боловсруулахаар ажиллаж байна. Тус зохицуулалтыг бий болгосноор манай улсын эдийн засгийн гол хөдөлгөгч хүчний нэг бөгөөд тасралтгүй эргэх мөнгөний урсгалын нэлээд хэсгийг бүрдүүлэгч үл хөдлөх хөрөнгийн салбараар дамжуулан хөрөнгийн зах зээлийг төрөлжүүлж, орон сууц, худалдааны төв, оффис зэрэг үл хөдлөх хөрөнгийг хөрөнгө оруулагчдад илүү хүртээмжтэй, эрсдэл багатай байдлаар санал болгох боломжийг бүрдүүлэх юм.

***Та өмнөх яриандаа нийгмийн болон тогтвортой байдлын бонд гаргахтай холбоотой зохицуулалтын орчныг өнгөрсөн сард бүрдүүлсэн талаар дурдаж байсан. Тэгвэл эдгээр бондын гол онцлог, бусад төрлийн үнэт цаастай харьцуулахад ялгаа нь юунд оршиж байна вэ?***

Нийгмийн болон тогтвортой байдлын бонд нь байгаль орчин, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлэх боломжийг олгодог гэдгээрээ онцлогтой.

Тухайлбал, нийгмийн бондын хүрээнд жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх, эрүүл мэнд, боловсрол, орон сууц зэрэг нийгмийн салбарыг дэмжих төслүүдийг санхүүжүүлэх боломжтой болж байна. Харин тогтвортой байдлын бонд нь ногоон болон нийгмийн төслүүдийг хослуулан хэрэгжүүлэх санхүүгийн хэрэгсэл бөгөөд байгаль орчинд ээлтэй, нийгэмд үр нөлөөтэй төсөл, хөтөлбөрүүдийг нэгэн зэрэг дэмжих зорилготой.

Энэ төрлийн үнэт цаас нь зах зээлд хариуцлагатай, нийгэм, хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлэх хөрөнгө оруулалтын соёлыг төлөвшүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Бидний гол зорилго бол хөрөнгө оруулагчдын хандлагыг эергээр өөрчилж, тогтвортой хөгжил, нийгмийн сайн сайхныг хөрөнгө оруулалтаар дэмжих боломжтойг олон нийтэд ойлгуулах юм.

Санхүүгийн зохицуулах хорооноос олон улсын чиг хандлага болон хөрөнгө оруулагчдын сонирхолд нийцүүлэн, тогтвортой санхүүжилтийн экосистемийг бий болгохыг зорьж ажиллаж байна. Тухайлбал, 2021 онд “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-д ногоон бондтой холбоотой зохицуулалтыг тусгаж, байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрүүдийг дотоодын хөрөнгийн зах зээлээр дамжуулан санхүүжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Үүний үр дүнд өнөөдрийн байдлаар нийт гурван үнэт цаас гаргагч нийт 48 сая ам.долларын ногоон бондыг амжилттай арилжаалсан нь энэ төрлийн үнэт цаасны зах зээлд эрэлт, хэрэгцээ байгааг харуулж байна.

Цаашид зөвхөн ногоон бонд төдийгүй нийгмийн болон тогтвортой байдлын бондыг багтаасан өргөн хүрээтэй зохицуулалтын орчныг бүрдүүлснээр манай улс тогтвортой санхүүжилтийн үндэсний тогтолцоог төлөвшүүлэх чухал алхам хийж байгаа юм.

Эдгээр зохицуулалт, санаачилгууд нь “Алсын хараа-2050”, “Тогтвортой санхүүгийн үндэсний замын зураг”, “Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл (2020–2025)”, “Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, мөн “Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний тодорхойлсон хувь нэмэр” зэрэг улс орны хөгжлийн

бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг санхүүгийн салбарын хүрээнд бодитоор дэмжих суурь нөхцөлийг бүрдүүлж байгаагаараа онцгой ач холбогдолтой.

***Саяхан манай улсад анхны жөндөр бонд гарлаа. Тус бонд нь бусад бондуудаас ямар ялгаатай вэ?***

“ХААН Банк” ХК–ны зүгээс 30.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий нийгмийн бондын нэг төрөл болох жөндөр бондыг анх удаа Монгол Улсын хөрөнгийн зах зээлд амжилттай гаргалаа. Энэхүү бонд нь олон улсын Sustainable Fitch байгууллагаар нийгмийн бондын зарчимтай нийцсэн дүгнэлт гаргуулсан бөгөөд жендерийн эрх тэгш байдлыг хангах, эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн гэдгээрээ онцлогтой. Түүнчлэн Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (ICMA)–ны нийгмийн бондын зарчимд нийцсэний зэрэгцээ олон улсын байгууллагаар зээлжих зэрэглэл тогтоолгосон тул дээрх бондыг барьцаагүйгээр гаргаж байгаа бөгөөд жендерийн тэгш байдлыг хангах, хөдөлмөр эрхлэлт, эмэгтэйчүүдийн нийгэм–эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг нийгэмд эерэг нөлөө үзүүлэхүйц төсөл хөтөлбөрүүдийг дэмжих зорилгоор “Нийгмийн бондын санхүүжилтийн хүрээ”–нд тодорхойлсон эмэгтэй бизнес эрхлэгчдийн бизнесийг санхүүжүүлэх юм.

Мөн нийгмийн болон тогтвортой байдлын бондууд нь зөвхөн дотоодын хөрөнгө оруулагчдыг татахад төдийгүй олон улсын хөрөнгө оруулагчдын анхаарлыг Монголын зах зээлд хандуулах чухал хөшүүрэг болж байна. Учир нь дэлхий нийтээр нийгмийн хариуцлага, тогтвортой байдалд чиглэсэн хөрөнгө оруулалтын эрэлт эрчимтэй өсөж, олон улсын санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын сангууд “ESG” буюу БОНЗ–ын үзүүлэлтэд суурилсан санхүүгийн бүтээгдэхүүнд илүүтэй хөрөнгө оруулж буй өнөө үед Монголын зах зээлд ийм төрлийн бүтээгдэхүүн нэвтрүүлсэн нь чухал ач холбогдолтой томоохон алхам болсон юм.

***Сүүлийн жилүүдэд Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх хүрээнд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг олон улсад таниулах, сурталчлах, гадаадын хөрөнгө оруулагчдын идэвх сонирхлыг нэмэгдүүлэх тал дээр ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байна. Энэ тал дээр Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс ямар арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллаж байгаа талаар манай сэтгүүлийн уншигчдад дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч.***

Санхүүгийн зохицуулах хороо гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. Тухайлбал, Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсын хөрөнгийн зах зээлтэй холбох, дотоодын аж ахуйн нэгжүүдийг олон улсын зах зээлд гаргах, хөрөнгө оруулагчдын дунд сурталчлан таниулах чиглэлээр шат дараалсан бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа билээ.

Үүнд, нээлттэй компаниудыг гадаадын хөрөнгийн бирж дээр давхар бүртгүүлэх, хадгаламжийн бичиг /depository receipt/

гаргахад дэмжлэг үзүүлэх, санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, компаниудын тайлан, мэдээллийг англи хэл дээр бэлтгэн түгээх, хөрөнгө оруулагчидтай харилцах харилцааг сайжруулах зэрэг олон чиглэлд бодит ажлууд хийгдэж байна.

Тухайлбал, Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсад сурталчлан таниулах зорилгоор БНХАУ–ын Шанхай, засаг захиргааны онцгой бүс Хонконг, АНУ–ын Нью–Йорк, Сингапур, БНСУ–ын Сөүл зэрэг дэлхийн санхүүгийн төв болсон томоохон хотуудад “Mongolian Capital Market Day”, “Mongolia’s Capital Market Connectivity”, “Mongolian Investment Forum” зэрэг олон улсын арга хэмжээг амжилттай зохион байгуулсан нь энэхүү бодлогын тод жишээ юм. Эдгээр арга хэмжээ нь зах зээлийн хөгжил, хөрөнгө оруулалтын урсгалыг нэмэгдүүлэх, олон улсын хамтын ажиллагааг дэмжихэд чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Нэмж дурдахад, 2025 оны онцлох үйл явдлын нэг нь Монгол Улсад анх удаа зохион байгуулагдах гэж буй Азийн үнэт цаасны 30 дахь удаагийн ерөнхий форум юм. Энэхүү форум нь бүс нутгийн нэр хүндтэй зохицуулагч, дэд бүтцийн байгууллагуудыг нэгтгэж, Монголын хөрөнгийн зах зээлийг олон улсад сурталчлах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, дотоодын компаниудыг таниулах чухал боломжийг бүрдүүлнэ гэж харж байна.

Түүнчлэн форумын хүрээнд “Mongolia’s Capital Market Connectivity” тусгай арга хэмжээг төр, хувийн хэвшлийн төлөөллүүдтэй хамтран зохион байгуулж, зах зээлийн онцлог, хөрөнгө оруулалтын боломж, тулгамдаж буй сорилт, хөгжлийн чиг хандлагын талаар мэргэжлийн хэлэлцүүлэг өрнүүлэхээр төлөвлөсөн.

Цаашид ч энэхүү арга хэмжээг олон улсын зохицуулагч байгууллагууд, хөрөнгийн биржүүд, холбоод болон холбогдох санхүүгийн байгууллагуудтай хамтран олон улсын санхүүгийн төвүүдэд зохион байгуулахыг зорьж байна. Энэ нь ирэх жилүүдэд гадаадын хөрөнгө оруулагчдын Монгол Улсад хөрөнгө оруулах идэвх, сонирхол улам бүр нэмэгдэхэд томоохон түлхэц болно гэдэгт итгэлтэй байна.

Үүнээс гадна, гадаадын хөрөнгө оруулагчдын дотоодын хөрөнгийн зах зээлд оролцох нөхцөлийг сайжруулах зорилгоор үнэт цаасны данс нээх үйл явцыг хялбаршуулах чиглэлээр салбарын оролцогчидтой хамтран ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, гадаадын иргэн, аж ахуйн нэгжүүд Монголын хөрөнгийн зах зээлд хүндрэл, чирэгдэл багатайгаар оролцох боломжийг бий болгоход шаардлагатай арга хэмжээ, санал санаачилга гарган ажиллаж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс цаашид ч гадаадын хөрөнгө оруулагчдыг татах бодлого, арга хэмжээгээ эрчимжүүлж, хөрөнгө оруулалтын орчныг тасралтгүй сайжруулах чиглэлд тууштай ажиллах болно.

# ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## КАРБОН ЗАХ ЗЭЭЛ

Сүүлийн жилүүдэд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт шууд болон шууд бус нөлөөг авчирч буй тул хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь дэлхийн улс орнуудын нэн тэргүүний зорилт болж байна. Иймд улс орнууд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлд олон талт бодлого, эдийн засгийн хэрэгслүүдийг нэвтрүүлж эхэлсэн. Үүний нэг жишээ нь хүлэмжийн хийг эдийн засгийн үнэлэмж бүхий арилжааны нэгж болгож солилцох орон зай буюу карбон зах зээл бөгөөд энэ нь тогтвортой хөгжлийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Карбон гэдэг нь нүүрстөрөгчийн давхар ислийн (CO<sub>2</sub>) болон бусад хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих нэгж юм. Харин эдгээр ялгарлыг бууруулах зорилгоор эдийн засгийн эргэлтэд оруулж буй механизмыг карбон кредит гэх ба нэг карбон кредит нь нэг тонн CO<sub>2</sub> эквивалент хэмжээний ялгарлыг бууруулсан байдлыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, байгаль орчны үр нөлөөг санхүүгийн нэгж болгон хөрвүүлснээр зах зээлд оролцогч талууд уур амьсгалын хариуцлагатай үйл ажиллагаа явуулах эдийн засгийн урамшуулал авах боломж бүрддэг. Дээр дурдсанчлан карбон зах зээл нь энэхүү кредитийг арилжаалах, баталгаажуулах, үнэ тогтоох тодорхой процесс бүхий үйл ажиллагаа явагдаж буй эдийн засгийн орон зай бөгөөд үүнийг олон улсын болон дотоодын зах зээл гэж газар зүйн хамрах хүрээгээр, мөн хэрэгжих хэлбэрээр нь зайлшгүй дагаж мөрдөх (compliance market) ба сайн дурын (voluntary market) зах зээл гэж ангилдаг.

Карбон зах зээлийн суурь эрх зүйн орчин нь 1992 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (UNFCCC) батлагдсанаар бүрдсэн. Тус конвенц нь хүлэмжийн хийн ялгарлын улмаас үүсэх дэлхийн дулаарлын асуудлыг олон улсын түвшинд анх удаа хүлээн зөвшөөрч, улс орнууд хамтран ажиллах суурь зарчим, зорилгыг тодорхойлсон (UNFCCC, 1992). Уг конвенцын үргэлжлэл болгон 1997 онд Японы Киото хотноо болсон UNFCCC-ийн Оролцогч Талуудын 3 дугаар бага хурлаар Киотогийн протокол батлагдсан. Энэхүү протокол нь аж үйлдвэржсэн 37 улс оронд хүлэмжийн хийн ялгаруулалтыг 2008–2012 он хүртэл нийт 5.2 хувиар бууруулах эрх зүйн үүрэг хүлээлгэж, анхны тоон зорилтыг олон улсын түвшинд хуульчлан тогтоосон (Зураг).

Зураг. Карбон зах зээлийн зохицуулалт




Эх сурвалж: Азийн хөгжлийн банк

Гэсэн хэдий ч Киотогийн протокол нь энэхүү үүргийг зөвхөн хөгжингүй орнуудад хүлээлгэж хөгжиж буй орнуудын оролцоог хангалтгүй тусгасан байна. Үүний үр дүнд 2015 онд Парис хотод зохион байгуулагдсан UNFCCC-ийн Оролцогч Талуудын 21 дүгээр бага хурлаар Парисын хэлэлцээр батлагдаж, дэлхийн 196 улс уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг эрх зүйн үүрэг бүхий анхны өргөн хүрээтэй хэлэлцээрт нэгдсэн. Тус хэлэлцээрийн хүрээнд улс орнууд дэлхийн дундаж температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх түвшинтэй харьцуулахад 2°C-аас доош, цаашлаад 1.5°C-д хязгаарлах зорилт тавьсан бөгөөд үүний хэрэгжилтийг хангахын тулд үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрээ таван жил тутам шинэчилж, шат дараатайгаар нэмэгдүүлэх үүрэг хүлээсэн (IPCC, 2018).

2021 онд Парисын хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн хэрэгжилтийн нарийвчилсан зохицуулалт батлагдсанаар уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, карбон кредитийг шилжүүлэх, арилжаалах эрх зүйн үндэс бүрдсэн юм. Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт нь улс орнууд хоёр талын тохиролцоонд (санамж бичигт) үндэслэн хүлэмжийн хийн бууруулалтыг карбон кредит (ITMO хэмээн нэрлэдэг) хэлбэрээр арилжаалах боломжийг олгодог бол 6.4 дүгээр заалт нь олон улсын төвлөрсөн нүүрстөрөгчийн зах зээлийг бий болгон гуравдагч этгээдээр баталгаажсан карбон кредитийг төрийн болон хувийн байгууллагууд арилжаалах нөхцөлийг бүрдүүлдэг (UNFCCC, 2021). Эдгээр нь Киотогийн протоколын сул тал болох давхар тооцоолол, улс орны идэвх оролцоо дутмаг байгаа зэргийг засахад чиглэж уур амьсгалын зорилтыг хэрэгжүүлэхэд ногоон хөрөнгө оруулалт, тогтвортой хөгжлийг дэмжих санхүүгийн чухал хэрэгсэл болсон.

Цаашлаад үзэхэд карбон кредит үүсгэж зах зээлд арилжаалах үйл явцыг авч үзвэл аж ахуйн нэгж, байгууллагууд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгоор тодорхой төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийх ба энэхүү хөрөнгө оруулалтын үр дүнд сэргээгдэх эрчим хүч ашиглах, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх зэрэг бодит хүлэмжийн хийн бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Ийнхүү хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд буурсан хүлэмжийн хийн хэмжээ нь олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, шалгуурыг хангасан тохиолдолд эрх бүхий байгууллага баталгаажуулж, нүүрстөрөгчийн кредит үүсгэн бүртгэнэ. Үүний үр дүнд тухайн аж ахуйн нэгж баталгаажсан нүүрстөрөгчийн кредит эзэмших эрхтэй болсноор карбон кредитийг зах зээлд арилжаалах, ашиглах эсвэл өөрийн уур амьсгалын зорилтоо биелүүлэхэд тооцох боломжтой(Зураг).

Зураг. Карбон кредит үүсгэх үйл явц



Эх сурвалж: Азийн хөгжлийн банк

# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ БА СОЁЛ

### ТУЗ–өөс засаглалын тогтолцоог бэхжүүлэх



ТУЗ нь компанийн чанар, удирдлага, санхүүгийн үйл ажиллагааг хянах үндсэн үүрэгтэй. Тиймээс ТУЗ–ийн гишүүд, захирлууд нь гүйцэтгэх удирдлагатай хамтран бодлогын хэрэгжилт, шинэчлэлийн асуудлыг тогтмол хэлэлцэж байх шаардлагатай.

Гүйцэтгэх удирдлага нь ТУЗ–д соёлын зөрчил, анхаарах асуудлууд, хэрэгжүүлж буй засаглалын арга хэмжээнүүдийн талаар нээлттэй мэдээлэл өгч байх ёстой. Ингэснээр ТУЗ нь байгууллагын зорилго болон ажилтнуудын эрмэлзлийг уялдуулах механизмыг бүрдүүлж өгдөг.

### Соёл ба засаглалын тэнцвэр

Нээлттэй ил тод, боловч сул засаглалтай байх нь хууль зөрчих, нэр хүнд унах эрсдэлийг үүсгэж болзошгүй. Харин эсэргээгээ хатуу дүрэм, журамд баригдсан засаглал нь ажилтны сэтгэл ханамжийг бууруулах, удирдлагын хэт хяналт буюу “micromanagement”–д хүргэх, хүний нөөцийн тогтворгүй байдал бий болгох эрсдэлтэй.

Тиймээс ТУЗ нь компанийн соёл ба засаглалын тэнцвэрийг хадгалах, ажилтнуудыг идэвхтэй байлгах, шинэ үеийн шаардлагад нийцүүлэхэд гүйцэтгэх удирдлагад чиглэл өгөх нь чухал.

### Тэнцвэрийг хэрхэн хангах вэ?

#### 1. Дүрмийг энгийн, ойлгомжтой хэлбэрээр танилцуулах

Ажилтнууд дүрмийг зөвхөн хууль журмын хүрээнд биш, өөрсдийн ажил амьдралтай уялдаатай хэмээн мэдэвэл түүнийг хэрэгжүүлэх идэвх нэмэгддэг. Жишээ нь, шинэ бодлого танилцуулахдаа сургалтын арга хэмжээ, кейс

судалгаанд суурилсан дадлага зэргээр ажилтны оролцоог хангах арга замыг ТУЗ санал болгож болно.

Мэдээллийн аюулгүй байдлын дүрмийг танилцуулахдаа мэдээлэл алдагдсан нөхцөлд шууд гарах эрсдэлийг ажилтнууд биечлэн мэдрэх байдлаар сургалт зохион байгуулах нь илүү үр дүнтэй. Мөн зөрчил гарсан тохиолдолд үүсэх үр дагавар, хуулийн хариуцлагын талаарх жишээ, статистик мэдээллийг ашиглан ажилтнуудыг соёл, дүрэм, журмыг дагаж мөрдөхөд идэвхжүүлэх боломжтой.

#### 2. Соёлын хэмжүүрүүдийг тогтмол хянах

Соёлын төлөв байдлыг хэмжих олон төрлийн шалгуур үзүүлэлт байдгаас тухайн байгууллагын онцлогт тохирох хамгийн чухал үзүүлэлтүүдийг сонгон тогтмол хянах нь үр дүнтэй.

Ажилтнуудын соёлын чиг хандлага, зан төлөв, эрсдэлийн мэдрэмж зэргийг шинжлэх замаар соёлыг хэмжих нь засаглалын уялдааг хянах үр дүнтэй арга юм. Мөн ажилтнууд болон хэрэглэгчдийн санал бодлоос гадна цахим платформууд, салбарын тайлан зэрэг гадаад орчны мэдээллийг ашигласнаар компанийн соёл, нэр хүндийг бүхэлд нь үнэлэх боломжтой.

#### 3. Удирдлагаас хариуцлагын соёлыг төлөвшүүлэх

ТУЗ нь байгууллагын амжилт зөвхөн гүйцэтгэх удирдлага бус, бүх түвшний хамтын хариуцлага дээр суурилдаг болохыг онцлох хэрэгтэй. Удирдах албан тушаалтны цалин урамшуулал, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг байгууллагын соёлын үнэт зүйлсэд уялдуулах нь чухал. Ингэснээр дээд түвшний удирдлагууд үлгэр дуурайлал үзүүлж, байгууллагын бусад түвшний ажилтнуудын хандлага, зан үйлд нөлөө үзүүлдэг.

Гүйцэтгэх удирдлагын дотоод, гадаад харилцаа, ажилтнуудын санал хүсэлт, тэдний хариу арга хэмжээ зэрэг нь соёлын төлөв байдлыг илэрхийлэх найдвартай үзүүлэлт болж чадна. Жишээ нь, оффисын цэвэрлэгч хаягдсан цааснаас нууц мэдээлэл бүхий бичиг олж, зохих ажилтанд нэн даруй мэдээлснээр мэдээллийн аюулгүй байдлын зөрчлөөс сэргийлж болно.

Дүгнэхэд, Компанийн засаглал ба соёл нь салшгүй уялдаатай, бие биеэ нөхөж байж байгууллагыг тогтвортой хөгжил, амжилтад хүргэдэг. Харин ТУЗ нь энэхүү тэнцвэрийг хадгалах, цаг үеийн шаардлагад нийцүүлэх гол хөшүүрэг юм.

# ФИНТЕК БА РЕГТЕК

## ШИЛДЭГ 10: РЕГТЕК КОМПАНИУД

Сэтгүүлийн энэ удаагийн дугаараар та бүхэндээ 2025 оны шилдэг 10 регтек компаниудыг танилцуулахаар бэлтгэлээ. Регтек буюу зохицуулалтын технологи нь санхүүгийн салбарын нийцлийн үйл явцыг хялбарчилж, зардал бууруулж, эрсдэлээс хамгаалах чухал хэрэгсэл болжээ. Регтек нь хөдөлмөр их шаардсан нийцлийн ажлуудыг автоматжуулж, луйврын илрүүлэлтийг сайжруулан, хэрэглэгчийн мэдээллийг алсаас баталгаажуулж, сэжигтэй гүйлгээг тодорхойлохын тулд гүйлгээний явцыг бодит цагийн хяналтад байлгах боломжийг олгодог. Энэхүү мэдээллийг Fintech magazine-аас эрхлэн гаргадаг ШИЛДЭГ 10 нийтлэлийн хүрээнд бэлтгэв.

### 10. ThetaRay



Гүйцэтгэх захирал: Peter Reynolds  
Төв байр: Ход ха–Шарон, Израил  
Байгуулагдсан он: 2013 он

MIT-д боловсруулагдсан өвөрмөц математик загварыг ашиглан, энэхүү Израил компани 2013 оноос хойш санхүүгийн гэмт хэргийг илрүүлэх салбарт хувьсгал хийжээ. Гүйцэтгэх захирал Peter Reynolds-ын удирдлага дор ThetaRay-ийн технологи нь уламжлалт системүүдийн анзааралгүй өнгөрөөдөг хэвийн бус болон сэжигтэй үйл ажиллагааг илрүүлдэг. Cloud суурьтай энэхүү платформ нь санхүүгийн байгууллагуудыг урьд өмнө танигдаагүй мөнгө угаах схем, терроризмыг санхүүжүүлэх сүлжээ, нарийн төвөгтэй луйврын оролдлогыг өндөр нарийвчлалтай илрүүлэх боломжтой болгосон. Дэлхийн хэмжээний томоохон төлбөрийн сүлжээнүүдтэй байгуулсан хамтын ажиллагаа нь хил дамнасан гүйлгээний хяналтын чадавхыг эрс нэмэгдүүлж, илрүүлэлтийн үнэн зөв байдлыг сайжруулжээ.

### 9. Fenergo



Гүйцэтгэх захирал: Marc Murphy  
Төв байр: Дублин, Ирланд  
Байгуулагдсан он: 2009 он

Fenergo нь 2009 онд Ирландад байгуулагдсан бөгөөд санхүүгийн байгууллагуудын үйлчлүүлэгчийн мэдээлэл,

элсүүлэлт, KYC (үйлчлүүлэгчээ таних), зохицуулалтын шаардлагыг олон улс дамнаулан хялбар, уялдаа холбоотой удирдах боломжийг олгодог алдартай платформ юм. Энэ системийг хөрөнгийн удирдлага, корпорацийн банк, хөрөнгийн менежмент зэрэг салбарууд өргөн ашигладаг. 2021 онд Astorg болон Bridgepoint компаниудад нэгдсэнээр Fenergo нь зохицуулалтын ухаалаг шийдлээ сайжруулж, Хойд Америк, Европ, Ази зэрэг бүс нутгуудад үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

### 8. Hummingbird



Гүйцэтгэх захирал: Joe Robinson  
Төв байр: Сан Франциско, АНУ  
Байгуулагдсан он: 2017 он

Hummingbird нь 2017 онд Сан Францискод байгуулагдсан бөгөөд санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх ажил, ялангуяа мөнгө угаахтай холбоотой мөрдөн шалгалтыг илүү ухаалаг, хамтын ажиллагаанд тулгуурласан байдлаар хийх боломжийг олгодог платформ хөгжүүлсэн. Үүсгэн байгуулагч CEO Joe Robinson нь Square, Stripe болон АНУ-ын Сангийн яамны туршлагатай мэргэжилтнүүдтэй хамтран энэ компанийг байгуулжээ. Тэдний платформ нь ухаалаг өгөгдөлд үндэслэн илрүүлэлтийн чанарыг сайжруулж, мөрдөн шалгалтын хугацааг богиносгодог. Мөн мэдээллийг илүү ойлгомжтой, утга агуулгатай байдлаар зохион байгуулж, санхүүгийн луйвартай тэмцэж буй финтек болон орчин үеийн банк санхүүгийн байгууллагуудын гол хэрэглээ болж байна.

## 7. Entrust (Onfido)



Гүйцэтгэх захирал: Todd Wilkinson  
Төв байр: Миннеаполис, Миннесота, АНУ  
Байгуулагдсан он: 1969 он (Onfido – 2012 он)

Entrust нь стратегийн худалдан авалтын хүрээнд Лондонд үүсгэн байгуулагдсан Onfido компанийг 2012 онд худалдан авснаар өөрийн зохицуулалтын технологийн (RegTech) чадавхыг эрс нэмэгдүүлсэн. Onfido нь хиймэл оюун ухаанаар ажилладаг биометр баталгаажуулалт болон баримт бичгийн нууцлал шалгалтын дэвшилтэт технологийг Entrust-ийн аюулгүй байдлын шийдэлд нэгтгэсэн. Энэхүү нэгдсэн шийдэл нь санхүүгийн байгууллагуудын KYC/AML (үйлчлүүлэгчээ таних болон мөнгө угаахтай тэмцэх) зохицуулалтад нийцэхэд зайлшгүй шаардлагатай өндөр нарийвчлалтай таних баталгаажуулалтын чадварыг бий болгож байна. Entrust нь Onfido-ийн машин сургалтын алгоритм болон царай таних биометр технологийг өөрийн дижитал аюулгүй байдлын дэд бүтцэд нэгтгэснээр дижитал элсэлт, хувийн мэдээллийн луйвраас сэргийлэх, тогтмол таних баталгаажуулалтын шаардлагуудыг хангах иж бүрэн нийцлийн шийдлийг дэлхийн зохицуулалттай салбаруудад санал болгож байна.

## 6. Jumio



Гүйцэтгэх захирал: Robert Prigge  
Төв байр: Пало-Альто, Калифорни, АНУ  
Байгуулагдсан он: 2010 он

2010 онд байгуулагдсан Jumio компани нь төлбөр баталгаажуулалтын үйлчилгээ үзүүлдэг компаниас дижитал таних баталгаажуулалтын цогц платформ руу хөгжсөн. Гүйцэтгэх захирал Robert Prigge-ийн удирдлага дор энэхүү Калифорнигийн инновацлаг компани нь дижитал таних баталгаажуулалтын тэргүүлэгч болж, “KYX” платформуороо дамжуулан таних баталгаа болон мөнгө угаахтай тэмцэх (AML) чиглэлд тэргүүлэх шийдлийг санал болгож байна.

Хиймэл оюун ухааны технологид суурилсан Jumio-ийн систем нь дэлхийн олон улс, бүс нутагт хэрэглэгчийн таних мэдээллийг бодит цаг хугацаанд баталгаажуулж, бичиг баримт шалгалтаас эхлээд тасралтгүй хяналт хүртэлх бүх процессыг хэрэглэгчдэд хялбар, үр дүнтэй байдлаар зохион байгуулдаг.

## 5. Forter



Гүйцэтгэх захирал:

Michael Reitblat  
Төв байр: Нью-Йорк, АНУ  
Байгуулагдсан он: 2013 он

Цахим худалдааны салбарт шинэчлэл авчирсан Forter компани нь 2013 онд Израилийн кибер аюулгүй байдлын салбараас үүсэлтэй бөгөөд дараа нь Нью-Йорк хотод төв байртай болсон. Үүсгэн байгуулагч бөгөөд гүйцэтгэх захирал Michael Reitblat-ын удирдлага дор тус компани нь Nordstrom, Sephora, Adobe зэрэг нэр хүндтэй үйлчлүүлэгчдийн гүйлгээг боловсруулдаг хэмжээнд хүрч, өндөр амжилтад хүрсэн. Forter-ийн бодит цагийн шийдвэр гаргах систем нь сүлжээний нарийн ухаалаг мэдээлэлд тулгуурлан луйвар, аккаунт алдахаас сэргийлэхийн зэрэгцээ жинхэнэ хэрэглэгчдэд илүү сайн туршлага бий болгодог. Тэдний “Identity Protection” буюу хувийн мэдээллийг хамгаалах бүтээгдэхүүн нь хадгалсан төлбөрийн мэдээллийг ашиглан хийх хуурамч худалдан авалтуудыг хаах чухал хэрэгсэл болсон.

## 4. Elliptic



Гүйцэтгэх захирал: Simone Maini  
Төв байр: Лондон, Их Британи  
Байгуулагдсан он: 2013 он

Elliptic нь 2013 оноос эхлэлтэй бөгөөд криптовалют олны анхааралд өртөхөөс өмнө л блокчэйн шинжилгээний анхдагч болсон компани юм. CEO Simone Maini удирдлага дор Лондонд төвтэй энэ байгууллага нь крипто

зохицуулалтын чиглэлээр мэргэжлийн, найдвартай нэр хүндтэй болж чадсан. Тэдний өндөр нарийвчлалтай технологи нь дижитал хөрөнгийн бизнесүүдийг санхүүгийн гэмт хэрэг илрүүлж, зохицуулалтын өөрчлөгдөж буй орчинд зөв ажиллахад тусалдаг. Мөн тус компанийн судалгааны баг хууль сахиулах байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж, томоохон крипто гэмт хэргийн сүлжээнүүдийг таслан зогсоодог нь тэднийг энэ салбарын гол тоглогч болгожээ.

### 3. Ascent



Гүйцэтгэх захирал: Brian Clark

Төв байр: Чикаго, АНУ

Байгуулагдсан он: 2015 он

Ascent бол 2015 онд Чикаго хотод байгуулагдсан, зохицуулалтын шаардлагыг хялбарчлахад зориулагдсан ухаалаг технологи бүхий компани юм. Энэ компани нь нарийн төвөгтэй хууль, дүрмийг хиймэл оюуны тусламжтайгаар ойлгомжтой, хэрэгжүүлэхэд бэлэн болгож хувиргадаг. Үүсгэн байгуулагч бөгөөд гүйцэтгэх захирал Brian Clark нь өмнө нь арилжаачин байсан бөгөөд зохицуулалтын хүндрэл бэрхшээлийг сайн мэддэг нэгэн. Ascent-ийн платформ нь санхүүгийн байгууллагуудад олон улсын болон дотоодын олон шатлалтай дүрмийн шаардлагыг хялбархан удирдахад тусалдаг. Тэдний систем нь дүрэм бүрийн дагуу үүрэг хариуцлагыг ялган ангилж, нийцлийн багт яг юу хэрэгтэйг холбооны, мужийн болон орон нутгийн түвшинд тодорхойлоход тусалдаг.

### 2. ComplyAdvantage



Гүйцэтгэх захирал: Vatsa Narasimha

Төв байр: Лондон, Их Британи

Байгуулагдсан он: 2014 он

ComplyAdvantage нь 2014 онд Charles Delingpole байгуулсан, Лондонд төвтэй компани бөгөөд одоо Vatsa

Narasimha –гийн удирдлага дор ажиллаж байна. Тус компани хиймэл оюун ухаан болон машин сургалтыг ашиглан санхүүгийн гэмт хэргийн эрсдэлийг илрүүлэх, удирдах арга барилыг шинэчилж байгаа юм. Тэдний хиймэл оюунд суурилсан AML (мөнгө угаахтай тэмцэх) болон луйврын илрүүлэлтийн хандлага нь худал эерэг үр дүнг мэдэгдэхүйц бууруулж, хэрэглэгчийн бүртгэх процессыг хурдасгадаг. Тус компанийн динамик эрсдэлийн мэдээллийн сан нь янз бүрийн улс орнуудын зохицуулалтын шаардлагад нийцэн байнга шинэчлэгдэж, байгууллагуудыг өөрчлөгдөж буй орчинд үр дүнтэй ажиллах боломжоор хангадаг.

### 1. Chainalysis



Гүйцэтгэх захирал: Jonathan Levin

Төв байр: Нью-Йорк, АНУ

Байгуулагдсан он: 2014 он

2014 онд анхны криптовалют төвтэй мөрдөн шалгах платформ хэлбэрээр байгуулагдсан Chainalysis нь блокчэйн шинжилгээ, зохицуулалтын салбарын тэргүүлэгч компани болсон. Jonathan Levin удирдлага дор тус компани томоохон хөрөнгө оруулагчдаас их хэмжээний хөрөнгө татаж чадсан. Chainalysis-ийн технологи нь криптовалютын гүйлгээг бодит байгууллага, хүмүүсийн мэдээлэлтэй холбож, засгийн газар болон санхүүгийн байгууллагуудыг хууль бус гүйлгээг илрүүлэх, улам бүр нарийсаж буй виртуал хөрөнгийн зохицуулалтад нийцэхэд нь тусалдаг.

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАР ДАХЬ ФИНТЕК ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

**Гүйцэтгэсэн:**

Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн Б.Гал

#### ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлаар банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-аас харилцагч нарт хүргэж буй технологид суурилсан зээлийн үйлчилгээ буюу финтек зээлийн үйлчилгээний зохицуулалтын орчныг сайжруулах талаар судалсан болно.

Судалгааны ажлаар финтек зээлийн зохицуулалтыг хэрэгжүүлж буй улс орнуудын туршлагыг харьцуулан судалж, ББСБ-аас түүвэр судалгаа авсны үндсэн дээр цаашид сайжруулах шаардлагатай зохицуулалтын саналыг боловсрууллаа.

#### ОРШИЛ

Бичил санхүүгийн зээл нь бага, дунд орлоготой иргэдийн шаардлагатай хэрэгцээг хангах, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон бичил аж ахуйн нэгжүүдийн бизнесийг дэмжих санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх санхүүгийн чухал зах зээлийн нэг юм. “Финтек зээл”-ийн үйлчилгээ нь зээлийг цахим байдлаар хурдан шуурхай цаг алдалгүй авах боломжийг иргэд болон аж ахуй нэгжүүдэд олгосноор санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж байна.

Финтек зээл нь 1990–ээд оны сүүл үеэс буюу интернэт олон нийтэд түгээмэл болж эхэлсэн цагаас үүссэн. Түүний төрлүүд нь зах зээлийн динамик шинж чанараас шалтгаалан өөр өөр байдаг ч үндсэн дөрвөн хэд хэдэн төрөл байдаг. Финтек зээл нь уламжлалт зээлийг илүү боловсронгуй болгосон.

Финтек зээлийн эрхзүйн орчин болон зохицуулалтыг олон улсын түвшинд ч, улс орнуудын түвшинд ч тодорхой хэмжээнд боловсруулаад байгаа бөгөөд цаашид шинэ тутам гарч буй финтек бүтээгдэхүүн болон одоогийн боловсруулсан зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Монгол Улсад финтек зээлийн үйл ажиллагаа эрхэлж эхэлснээс хойш санхүүгийн хүртээмж илт нэмэгдсэн бөгөөд 2018–2023 онд 2.8 дахин өсөж давхардсан тоогоор 4,5 сая харилцагч үйлчлүүлж байна. Финтек зээлийн шинэ бүтээгдэхүүн турших финтек зээлийн зах зээлд цаашид ч олон боломжууд байгаа бөгөөд өсөх хандлагатай байгааг судлаачид онцолж байна.

Монгол Улсын хувьд бичил зээлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгодог ба сүүлийн жилүүдэд финтек зээлийн үйл ажиллагаа эрхлэх ББСБ-уудынтоо өсөж байгаа нь зохицуулалтын орчныг бүрдүүлэх түүний хяналт шалгалтыг сайжруулах хэрэгцээг үүсгэж байна. Иймээс олон улсын шилдэг зохицуулалтын туршлагыг мөн Монгол Улсын зохицуулалтын орчин хэрэглэгчид болон зээлийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдлыг судаллаа.

Энэхүү судалгааны ажлаар финтекийн тухай, ББСБ-уудын өнөөгийн финтек зохицуулалтын талаарх түүвэр судалгааг хийн, финтек зээлийн үйлчилгээний зохицуулалтаар Улс орнуудын сайн туршлагыг судалж, Монгол улсад хэрэгжүүлэх саналыг дэвшүүллээ.

## ФИНТЕК ЗЭЭЛ

Финтек зээл гэдэг нь онлайн технологи, дата аналитик ашиглан дижитал платформоор дамжуулан санхүүгийн зээл, зээлийн үйлчилгээ үзүүлэх үйл явцыг хэлнэ. Энэ нь зээлийн хүсэлт, шийдвэр, зарцуулалт, эргэн төлөлтийн үйл явцыг хөнгөвчлөхийн тулд цахим хуудас, гар утасны аппликэйшн, онлайн портал зэрэг дижитал сувгуудыг ашиглах явдал юм. Технологийн хурдацтай дэвшил, онлайн болон мобайл банкны үйлчилгээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор финтек зээл сүүлийн жилүүдэд түгээмэл болж байна.

Энэхүү орчин үеийн арга барилаар зээлдэгчид онлайн платформоор дамжуулан зээл авах хүсэлт гаргадаг. Зээлдүүлэгчид харилцагчийн зээлийн чадварыг үнэлэхийн тулд дэвшилтэт технологи, мэдээллийн аналитик ашиглаж үнэлдэг. Дараа нь зээлийн мэдээлэлүүдийг цахим хэлбэрээр эцэслэн боловсруулж, санхүүжилтийг дижитал хэлбэрээр олгодог. Зээлдэгч нь зээлийн эргэн төлөлтийг онлайнар хийдэг бөгөөд энэ нь зээлийн бүх үйл явцыг уламжлалт аргуудаас илүү үр ашигтай, оновчтой, хялбар болгож зээл олгох үйл явцад хувьсал хийсэн юм. Нэмж дурдахад финтек зээл нь нэгэн зэрэг хувь хүн, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, тав тухтай байдлыг бий болгож, санхүүгийн салбарт инновацыг дэлгэрүүлсэн.

Хүснэгт. Финтек зээлийн гол онцлог, давуу талууд

Тав тухтай байдал	Финтек зээл нь зээлдэгчдэд илүү тохиромжтой, хялбаршуулсан зээлийн процессыг санал болгож, зээлдэгчид хаа байгаа газраасаагаар утсаараа дамжуулан зээл авах боломжийг олгодог.
Хурдан шуурхай	Дижитал платформуыг ашиглах нь зээлийг илүү хурдан олгох, зээлийн төлбөрийн чадварыг үнэлэх ба санхүүжилт олгоход зарцуулдаг цаг хугацааг багасгадаг.
Хүртээмжтэй байдал	Финтек зээлийн платформууд нь уламжлалт банкны үйлчилгээг авах боломж хязгаарлагдмал алслагдсан бүс нутгийн иргэдийг оролцуулан илүү өргөн хүрээний хэрэглэгчдэд хүрч чаддаг.
Мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргах	Финтек зээл нь зээлийн эрсдэлийг үнэлэх, зээлийн шалгуурыг тодорхойлох, хувийн оноог тогтоох зорилгоор мэдээллийн аналитик, хиймэл оюун ухаан, машин сургалтын алгоритмуудыг ашигладаг.
Хэрэглэгчийн туршлагыг сайжруулсан	Зээлдэгч нь бодит цаг үеийн мэдээлэлд хандах, зээлийн статусаа хянах боломжтой байдаг.
Үйл ажиллагааны зардал бага	Финтек зээл олголт нь биет дэд бүтэц, бичиг баримтын хэрэгцээг багасгаж, улмаар зээлдүүлэгчдийн зардлыг хэмнэдэг.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт


## ФИНТЕК ЗЭЭЛИЙН ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дэлхийн финтек зээлийн зах зээлийн хэмжээ 2023 онд 13.1 тэрбум ам.долларт хүрчээ, 2033 он гэхэд CAGR буюу дэлхийн зах зээлийн дундаж өсөлт 23.4 хувиар өсөж 107 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.

Дэлхийн финтек зээлийн зах зээл нь тогтвортой өсөлтийг үргэлжлүүлэн харуулж мөн финтекийн экосистемд чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Кембрижийн алтернатив санхүүгийн төв (CCAF) болон дэлхийн эдийн засгийн форумын 2024 оны тайланд дурдсанаар финтек зээл нь дэлхийн финтекийн салбарын чухал хэсэг болж нийт финтекийн үйл ажиллагааны ойролцоогоор 27% –ийг бүрдүүлж байна. Энэхүү салбар нь ялангуяа уламжлалт банкны үйлчилгээ хязгаарлагдмал хөгжиж буй зах зээлүүдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

<sup>1</sup> <https://www.researchandmarkets.com/>

Зураг. Финтекийн үйл ажиллагаа төрлөөр



Эх сурвалж: Кембрижийн алтернатив санхүүгийн төв

Финтекийн зах зээл нь Ковид-19 цар тахлын дараа финтекийн зах зээлийн үйлчлүүлэгчдийн тоо өссөөр байгаа нь тахлын өмнөх болон тахлын үеэр ажиглагдсан өсөлтийн эрч хүчийг хадгалсаар байна. Дижитал санхүүгийн үйлчилгээний хүртээмж сайжирч, хэрэглэгчдийн сонирхол, финтек үйлчилгээний эрэлт нэмэгдсэн. Финтек зээлийн хэрэглэгчид мөн өсөлтөө хадгалсаар байгаа бөгөөд 2020–2022 оны хооронд харилцагчид жилд дунджаар 50%-иас дээш харилцагчийн өсөлт үзүүлсэн байна. Энэхүү өсөлт нь ялангуяа SSA болон APAC зэрэг бүс нутагт уламжлалт санхүүгийн байгууллагуудын үлдээсэн орон зайг нөхөж байгаагаараа онцлог юм.

Дэлхийн финтек зээлийн зах зээл өсөлттэй байгаа боловч бүс нутгийн сорилтуудтай тулгарч байна. Жишээлбэл: SSA –д өсөлт нь агентын сүлжээ болон дижитал дэд бүтцийн дутагдал зэрэг дэд бүтцийн хязгаарлалтаас болж саарсан байна. Эдгээр сорилтуудын хажуугаар бүс нутагт гар утасны цахим мөнгөний платформоос үүдэлтэй финтек зээлийн өсөлт өндөр хэвээр байна. Харин Европ, Хойд Америк зэрэг илүү хөгжингүй зах зээлүүд нь зохицуулалтын бэрхшээлүүдтэй тулгарч, олон финтек зээлийн цаашдын өсөлтийг саатуулж байгаа гол саад бэрхшээл болж байна.

Ирээдүйд финтек зээлийн зах зээл технологийн дэвшлүүд, ялангуяа хиймэл оюун ухаан болон их өгөгдлийн аналитик зэрэг технологиудын нөлөөгөөр хүчтэй өсөлтийг үргэлжлүүлнэ гэж хүлээгдэж байна. Эдгээр технологиуд нь зээлийн онооны загвар болон эрсдэлийн үнэлгээг сайжруулж байна. Гэсэн хэдий ч салбар нь үргэлжлэн өсөлтөө хадгалахын тулд зохицуулалтын үргэлжилсэн сорилтууд болон эдийн засгийн тодорхой бус байдалд анхаарлаа хандуулах

шаардлагатай болно. Мөн дээрх тайланд инновацыг дэмжихийн зэрэгцээ хэрэглэгчийг хамгаалах тэнцвэрийг хангах тодорхой зохицуулалтын хүрээг бий болгохыг онцолсон. Энэ нь ялангуяа хөгжиж буй зах зээлд маш чухал бөгөөд үр дүнтэй финтек зээлийн зохицуулалт нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой.

### Зохицуулалтын орчин

Финтек зээлийн талаар олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн зохицуулалтын стандарт, бодлого байхгүй бөгөөд улс орон бүр өөрийн санхүүгийн зах зээл дэх эрсдэлийг удирдах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Олон улсын төлбөр тооцооны банк (BIS) болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн (FSB) тайланд дурдсанаар, зохицуулалтын хандлагыг ерөнхийд нь гурван чиглэлд хувааж үздэг:

#### 1. Одоо байгаа хүрээг өөрчлөн зохицуулах

Олон улс оронд финтек зээлийг зохицуулахдаа одоо байгаа санхүүгийн зохицуулалтын хүрээг шинэ нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх замыг сонгосон байдаг. Энэ нь уламжлалт санхүүгийн байгууллагуудад мөрдөгддөг зохицуулалтыг финтек компаниудад хэрэгжүүлэхийг шаарддаг. Жишээлбэл: олон улс оронд финтек зээлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд банкны лиценз авах, мөнгө угаахтай тэмцэх (AML) болон үйлчлүүлэгчийг таних (KYC) журамд нийцэх ёстой байдаг. Энэ хандлага нь финтек зээл олгогчдыг тогтсон санхүүгийн байгууллагуудтай адил хэрэглэгчийг хамгаалах болон санхүүгийн тогтвортой байдлын шаардлагад нийцүүлэн хяналт тавих боломжийг бүрдүүлдэг.

## 2. Финтекд зориулсан шинэ зохицуулалт нэвтрүүлэх

Зарим улсад финтек зээлийн өвөрмөц онцлогийг хүлээн зөвшөөрч, холбогдох эрсдэл болон боломжийг шийдвэрлэх зорилгоор тусгай зохицуулалтыг боловсруулсан байдаг. Жишээ нь, Их Британийн санхүүгийн үйлчилгээний хороо (FCA) нь P2P платформуудыг зохицуулах зориулалттай системийг анхлан нэвтрүүлсэн. Эдгээр зохицуулалтууд нь ил тод байдал, эрсдэлийн удирдлага, хэрэглэгчийг хамгаалахад анхаардаг бөгөөд салбар дахь инновацыг дэмждэг. Үүнтэй төстэй байдлаар Хятад Улс P2P зээлийн платформуудад хатуу зохицуулалт нэвтрүүлсэн бөгөөд энэ нь луйвар болон санхүүгийн тогтворгүй байдалд хариу үйлдэл үзүүлэх зорилготой юм.

## 3. Финтек зээлийг дэмжихэд зориулсан бодлого

Зарим Засгийн газрууд финтек зээлийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ түүний эрсдэлийг үр дүнтэй удирдахын тулд бодлогын тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг. Тухайлбал Их Британи улсад финтекийн платформд хөрөнгө оруулж буй хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлэх мөн Их Британийн бизнесийн банк нь Funding Circle-тэй хамтран жижиг бизнесүүдэд зээл олгох Засгийн газрын дэмжлэгтэй санаачилгуудыг хэрэгжүүлж байна. Эдгээр бодлогын арга хэмжээнүүд нь салбар дахь хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, санхүүгийн үйлчилгээ хүртэхэд бэрхшээлтэй бүлэг болон жижиг бизнесүүдэд зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байдаг.

### Зохицуулалтын гол сорилтууд

Хэрэглэгчийн хамгаалалт: Дэлхий даяар хэрэглэгчийг хамгаалах асуудал нэн тэргүүнд тавигдаж байна. Зохицуулагчид зээлийн нөхцөл, болзлын ил тод байдлыг

сайжруулах, хууль бус өндөр хүүтэй зээлээс сэргийлэх, мөн хэрэглэгчдийг финтек зээлийн эрсдэлүүдийн талаар бүрэн ойлголттой болгох чиглэлд онцгойлон анхаарч байна.

Санхүүгийн тогтвортой байдал: Финтекийн зээл нийт зээлийн зах зээлийн томоохон хэсгийг эзлэх эрсдэлтэй учраас санхүүгийн тогтвортой байдалд зохицуулагчид анхааран ажиллаж байна. Зохицуулагчид финтекийн зээлийн эдийн засгийн мөчлөгөөс хамаарах хандлага буюу эдийн засгийн өсөлт, бууралттай уялдан зээлийн хүртээмж ихсэж, багасах хандлагад онцгой анхаарал хандуулж байгаа юм. Хөрөнгө оруулагчдын итгэл гэнэт алдагдах үед санхүүжилт хурдан татагдан, зээлийн хүртээмж огцом буурч, зах зээлийн тогтворгүй байдлыг улам хурцатгах аюултай байна.

Мэдээллийн нууцлал ба кибер аюулгүй байдал: Дижитал платформуудын хурдацтай хөгжил нь мэдээллийн нууцлал болон кибер аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавихыг шаарддаг. Зохицуулагчид финтекийн платформуудыг хэрэглэгчдийн мэдээллийг найдвартай хамгаалж, кибер халдлагаас сэргийлэх системтэй байхыг баталгаажуулах шаардлагатай байна.

Улс орнууд финтекийн зээлийн өгөөж болон эрсдэлийг удирдахад чиглэсэн өөр өөр аргуудыг нэвтрүүлсэн бөгөөд зарим нь одоо байгаа зохицуулалтуудаа өөрчлөн тохируулж, зарим нь энэ салбарт зориулсан шинэ зохицуулалтын хүрээ бий болгож байна. Зохицуулагчдын хувьд инновацыг дэмжихийн зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдал болон хэрэглэгчийг хамгаалах тэнцвэрийг хадгалах нь чухал сорилт хэвээр байна.

## ТАНЗАНИ УЛСЫН ФИНТЕК ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Танзани Улс Африк тивд дижитал санхүүгийн үйлчилгээ (DFS)-ний тэргүүлэгч болж, финтек зээлийн салбарт санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Танзани Улсын туршлага нь хариуцлагатай финтек зээлийн дадал болон тэдгээрийг дэмжих зохицуулалтын арга барилыг хөгжүүлэхэд үнэтэй сургамж болж байна. Энэ хэсэгт Танзани улсын финтек зээлийн зах зээлийн өсөлт, тогтвортой байдлыг хангахад нөлөөлсөн зохицуулалтын тогтолцоо, үндсэн зарчмуудыг судалсан болно.

### Танзани Улсын дижитал санхүүгийн үйлчилгээний хөгжил

Танзани Улсын дижитал санхүүгийн үйлчилгээний экосистем нь 2008 онд цахим мөнгөний үйлчилгээг нэвтрүүлснээс хойш ихээхэн хөгжиж эхэлсэн. Энэ салбар нь банкнууд, гар утасны сүлжээний операторууд (MNOs), болон FinTech компаниудын хоорондын хамтын ажиллагааны үр дүн юм. Энэхүү финтек зээлийн хөгжилд гарсан гол үйл явдлууд нь гар утасны мөнгөний шийдлүүд, гар утасны хадгаламж, зээлийн үйлчилгээ, гар утасны түрийвчүүдийн хоорондын шилжүүлэг зэрэг юм.

Танзани Улсын финтек зээлийн салбарт Vodacom Tanzania, Commercial Bank of Africa, Airtel, Tigo зэрэг томоохон компаниуд давамгайлдаг. Эдгээр үйлчилгээ үзүүлэгчид зээлийн бүтээгдэхүүнээ цахим мөнгө хэлбэрээр хэрэглэгчдийн гар утасны түрийвчинд шууд олгодог. Жишээлбэл, Vodacom Tanzania компани нь Commercial Bank of Africa-тай хамтран M-Pawa хэмээх дижитал хадгаламж, зээлийн үйлчилгээг нэвтрүүлсэн нь ихээхэн амжилт олсон.

#### **Финтек зээлийн зохицуулалтын тогтолцоо**

Танзани Улсын Төв банк (BOT) нь финтек зээлийн зохицуулалтыг дэмжих зохистой орчныг бүрдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Тус Улсын зохицуулалтын хандлага нь зах зээлд инновацыг дэмжих, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс "Суралцан турших" аргачлалыг нэвтрүүлсэн. Цаг хугацааны явцад BOT нь "Зааварчилж хяналт тавих" хандлага руу шилжсэн. Банк болон банкнаас бусаданхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянахдаа BOT нь Харилцаа Холбооны Зохицуулалтын Газартай (TCRA) нягт хамтран ажилладаг байна.

#### **Танзани Улсад финтек зээлийг зохицуулдаг гол журам, удирдамжууд:**

Танзани Улсын төв банкны тухай хууль (2006): Танзани улсын төв банк-ын үйл ажиллагааг хууль ёсны хүрээнд тогтоож өгөх суурь хууль юм. BOT-д тус улсын санхүүгийн систем, түүний дотор банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллагуудаар дамжуулан хийгддэг төлбөрийн системүүдийг хяналтдаа авах эрх мэдэл олгодог. BOT нь төлбөрийн системүүдийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор журам, заавар, удирдамж гаргах өргөн эрх мэдэлтэй. Энэ нь санхүүгийн тогтвортой байдал, хүртээмжийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Цахим мөнгөний зохицуулалт (2015): Энэхүү зохицуулалт нь Танзани дахь банкнаас бусад байгууллагуудаар дамжуулан цахим мөнгө (e-money) гаргах, удирдах бүрэн зохицуулалтын хүрээг бүрдүүлэхээр гарсан.

- ◆ Цахим мөнгө гаргах хүсэлтэй банкнаас бусад байгууллагууд, тухайлбал гар утасны операторын үйлчилгээ үзүүлэгч компаниуд BOT-оос лиценз авах шаардлагатай. Энэ нь зөвхөн чадварлаг, тогтвортой байгууллагууд электрон мөнгөний үйл ажиллагаа эрхлэх боломжийг олгодог.
- ◆ Цахим мөнгө гаргагч байгууллагууд нь өөрийн бусад бизнесийн үйл ажиллагаанаас тусдаа хуулийн этгээдээр ажиллах ёстой. Энэ нь электрон мөнгөний үйлчилгээтэй холбоотой

эрсдэлийг тусгаарлаж, хэрэглэгчдийг хамгаалахад тустай.

- ◆ Мөн цахим мөнгө гаргагч байгууллагууд нь гаргасан электрон мөнгөний үнэ цэнийг хадгалах зорилгоор лицензтэй банкнуудад итгэлцлийн данс нээх ёстой. Энэ нь цахим мөнгө гаргагч санхүүгийн хүндрэлтэй тулгарсан ч хэрэглэгчдийн мөнгийг хамгаалах баталгаа болдог.
- ◆ Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотойгоор цахим мөнгөний үйлчилгээтэй холбоотой хураамж, төлбөрийг тодорхой, ил тод мэдээлэхийг шаарддаг. Энэ нь хэрэглэгчид гүйлгээ хийхээсээ өмнө бүрэн мэдээлэлтэй байх боломжийг бүрдүүлдэг.

Агент банкны удирдамж (2017): Энэхүү удирдамж нь ялангуяа хөдөө орон нутаг болон үйлчилгээ хүрэхгүй байгаа газруудад банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг агентуудаар дамжуулан хүргэхийг зохицуулах зорилготой. Банкнууд болон санхүүгийн байгууллагууд гуравдагч этгээд болох агентуудыг агентуудыг (Жишээлбэл: жижиглэнгийн дэлгүүр, шуудангийн газар, хувь хүмүүс) өөрсдийн нэрийн өмнөөс үндсэн банкны үйлчилгээг санал болгохоор ажиллуулахыг зөвшөөрдөг. Эдгээр үйлчилгээнд бэлэн мөнгөний хадгаламж, зарлага, шилжүүлэг болон төлбөрийн үйлчилгээнүүд орно. Банкнууд болон санхүүгийн байгууллагууд агент банкны үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд BOT-оос зөвшөөрөл авах ёстой. Агентууд хэрэглэгчдийн өгөгдлийг аюулгүйгээр хадгалах ёстой ба нууцлалыг сахин мөрдөх ёстой. BOT нь агентуудын үйл ажиллагааг шалгах, хянах эрхтэй бөгөөд зохицуулалтын стандартыг хангаж буй эсэх, санхүүгийн системийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах үүднээс хяналт тавьдаг.

Бичил санхүүгийн тухай хууль (2018): Тус улсад үйл ажиллагаа явуулж буй бичил санхүүгийн байгууллагуудад (MFI), түүний дотор финтек зээлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад зориулсан зохицуулалтын хүрээг бий болгож өгсөн. Энэ нь ил тод байдлыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг хамгаалах, бичил санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дэмжих зорилготой.

- ◆ Хуульд дижитал платформоор дамжуулан бичил зээлийн үйлчилгээ үзүүлдэг этгээдүүдийг дижитал бичил санхүүгийн зээлдүүлэгчид гэж тодорхойлсон. Үүнд зээлийн хүсэлт, баталгаажуулалт, олголт, болон гар утас эсвэл бусад дижитал сувгуудаар дамжуулан төлбөрийг хүлээн авах зэрэг үйл ажиллагаанууд орно.

- ◆ Хуульд дижитал бичил санхүүгийн зээлдүүлэгчдэд зээлийн хүү, төлбөр, төлбөрийн хуваарь, болон хожимдуулсан төлбөрийн торгууль зэрэг зээлийн холбогдох бүх нөхцөлийг мэдээлэхийг шаарддаг. Энэ нь зээлдэгчид зээлийн өртөг, үүргийн талаар бүрэн ойлголттой болохыг баталгаажуулдаг.
- ◆ Хуульд зээлдэгчийг шударга бус зээл олголтын үйл ажиллагаанаас хамгаалах тусгай заалтуудыг агуулдаг. Энэ нь зээл олголтын нөхцөлийг тодорхой мэдээлэхийг шаарддаг ба хэт өндөр хүүгийн хураамжийг хязгаарлахыг шаарддаг.
- ◆ BOT нь бичил санхүүгийн байгууллагууд, финтек зээлдүүлэгчдийг хянах, тэднийг хуулийн дагуу ажиллах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахыг баталгаажуулах үүрэгтэй. Хууль нь финтек зээлдүүлэгчдийг BOT-д үйл ажиллагааны болон хэрэглэгчийг хамгаалах арга хэмжээнүүдийн талаар тогтмол тайлан гаргаж өгөхийг шаарддаг.

Эдгээр зохицуулалт нь тус улсад финтек зээлийн зохицуулалтын баг бэх тогтолцоог бүрдүүлж, инновацыг дэмжихийн зэрэгцээ хэрэглэгчдийн эрхийг хамгаалж, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

### **Танзани Улсын финтек зээлийн зохицуулалтын үндсэн зарчмууд**

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах: BOT нь ил тод байдал, хүү болон шимтгэлийн мэдээллийг дэлгэрэнгүйгээр гаргах, хэрэглэгчидтэй шударга байдлаар харьцах зэрэг бүх төрлийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах журмуудыг хэрэгжүүлдэг. Финтек зээлийн үйлчилгээ үзүүлэгчид бүх холбогдох мэдээллийг хэрэглэгчдэд ойлгомжтой, энгийн хэлээр хүргэж, хэрэглэгчдэд мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах боломжийг хангах ёстой.

Өрийн дарамтанд орохоос сэргийлэх: Өрийн дарамтанд орох эрсдэлийг бууруулахын тулд BOT нь зээлдэгчийн төлбөрийн чадварыг үнэлэхэд зээлийн мэдээллийн байгууллагуудыг ашиглахыг зөвлөж, зээлийн боломжит хэмжээг нээлттэй мэдээлэхээс зайлсхийхийг дэмждэг. Энэ нь зээлдэгчийн зээлийн хэмжээг хэтрүүлэхээс сэргийлэх арга хэмжээ юм. Мөн зээлийг хүсэлт илгээгээгүй байхад санал болгох болон хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр зээлийн хэмжээг автоматаар нэмэгдүүлэх үйлдлүүдийг хориглодог.

Мэдээллийн нууцлал ба аюулгүй байдал: BOT нь

финтек зээлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хэрэглэгчийн өгөгдлийг хамгаалахын тулд хүчтэй аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийг шаарддаг. Үйлчилгээ үзүүлэгчид гуравдагч этгээдтэй өгөгдөл хуваалцахын өмнө хэрэглэгчийн зөвшөөрлийг авах ёстой бөгөөд хувийн нууцын хуулиудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Хариуцлагатай үнэ тогтоох: Танзани Улсад финтек зээлийн хүүгийн хязгаар тогтоогдоогүй ч BOT нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн ногдуулж буй хүүг шударга, үндэслэлтэй эсэхийг хянадаг.

Инновац болон уян хатан байдал: BOT-ийн "суралцан турших" аргачлал нь инновацыг дэмжихийн зэрэгцээ эрсдэлийг удирдах зохицуулалтын орчныг бүрдүүлсэн. Энэ уян хатан хандлага нь үйлчилгээ хүрээгүй оролцогчдод бодит финтек зээлийн зах зээлийг хөгжүүлэх боломжийг олгосон.

Танзани Улсын финтек зээлийн зохицуулалтын хүрээ нь инновацыг, хэрэглэгчийн эрх хамгаалах, санхүүгийн тогтвортой байдалтай үр дүнтэйгээр тэнцвэржүүлж байна. Танзани Улс Төв банкны тухай хууль, Цахим мөнгөний зохицуулалт, Бичил санхүүгийн тухай хууль зэрэг чухал зохицуулалтуудаар дамжуулан санхүүгийн хүртээмжийг ихээхэн нэмэгдүүлсэн, эрчимтэй хөгжиж буй дижитал санхүүгийн экосистемийг бий болгож чадсан. Танзани улсын төв банкны "Суралцан турших" арга барил нь финтек зээлийг хариуцлагатайгаар өргөжүүлэх, ил тод байдал, шударга үнэ тогтоолт, хэрэглэгчийг хамгаалах баталгааг хангах боломжийг олгож байна. Тус улсын туршлага нь дижитал санхүүгийн системийг хөгжүүлэх эсвэл сайжруулахыг эрмэлзэж буй бусад улс орнуудад үнэтэй туршлага болж өгдөг.

## ДУГНЭЛТ

- ◆ Финтек зээлийн үйлчилгээ нь хэрэглэгчдэд санхүүгийн үйлчилгээг илүү хялбар, хурдан хүргэх боломжийг олгодог төдийгүй сүүлийн жилүүдэд интернэт болон гар утасны хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотойгоор энэ салбар хурдацтай хөгжиж байна. Технологийн дэвшил нь финтек зээлийг илүү хүртээмжтэй болгож, дэлхий даяар өргөжиж байгаа нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, хэрэглэгчдэд шинэ боломжуудыг бий болгосон.
- ◆ Ковид–19 цар тахлын үеэс хойш финтек зээлийн зах зээл хурдацтай тэлж байгаа бөгөөд дэлхийн олон улс орнууд энэ зах зээлийн өсөлтөд зориулсан зохицуулалтын орчныг сайжруулах шаардлагатай тулгарч байна. Улс орон бүр өөрийн онцлог, зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан зохицуулалтын тусгай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдал, мэдээллийн аюулгүй байдал зэрэг сорилтуудыг даван туулахад чиглэгдэж байна.
- ◆ Тухайлбал, Танзани Улсад финтек зээлийн зохицуулалт нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа ч мэдээлэл, чадавхын хувьд цаашид сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Харин өндөр хөгжсөн Их Британи Улсад зохицуулалтын орчин бүрдсэн бөгөөд Финтекийн зээлийн салбарт ил тод байдал, хэрэглэгчийн хамгаалалтад ихээхэн анхаарал хандуулдаг. Энэтхэг Улсын хувьд финтек зээлийн хурдацтай өсөлт нь хэрэглэгчийг хэт өрөнд оруулах, мэдээллийн нууцлалыг зөрчих зэрэг эрсдэлүүдийг зохицуулах шинэ журам, аргачлалыг авч хэрэгжүүлсэн.
- ◆ Монгол Улсын хувьд финтек зээлийн зохицуулалтын орчныг улам бүр сайжруулах хэрэгцээтэй байна. Эдгээр улс орнуудын туршлагаас суралцаж, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, зээлийн мэдээллийн санг сайжруулах, ил тод байдлыг хангах, зохицуулагч байгууллагын чадавхыг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай. Монгол Улсад финтек зээлийн өсөлтөөс үүдэн гарах эрсдэлүүдийг хянах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд зохицуулалтын орчныг илүү боловсронгуй болгож, инновацыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь нэн тэргүүний зорилт болно.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Reserve Bank of India. “Guidelines on Digital Lending.” 2022. Available at: <https://rbi.org.in/Scripts/NotificationUser.aspx?Id=12382&Mode=0>
2. Reserve Bank of India. “Digital Lending Guidelines.” 2022. Available at: <https://www.rbi.org.in/commonperson/English/Scripts/FAQs.aspx?Id=3413>
3. Reserve Bank of India. “THE CREDIT INFORMATION COMPANIES (REGULATION) ACT, 2005.” 2005. Available at: <https://www.indiacode.nic.in/bitstream/123456789/2057/2/A200530.pdf>
4. Reserve Bank of India. “Master Circular – Fair Practices Code.” 2011. Available at: <https://www.rbi.org.in/commonperson/English/Scripts/Notification.aspx?Id=867>
5. PRS India. “The Digital Personal Data Protection Bill.” 2023. Available at: <https://prsindia.org/billtrack/digital-personal-data-protection-bill-2023>
6. Reserve Bank of India. “Business Continuity Planning.” 2022. Available at: <https://rbi.org.in/scripts/PublicationReportDetails.aspx?UrlPage=&ID=622>

7. Ministry of Electronics & Information Technology. “National Cyber Security Policy.” 2013. Available at: [https://www.meity.gov.in/writereaddata/files/National\\_cyber\\_security\\_policy-2013\\_0.pdf](https://www.meity.gov.in/writereaddata/files/National_cyber_security_policy-2013_0.pdf)
8. Reserve Bank of India. “Draft Enabling Framework for Regulatory Sandbox.” 2019. Available at: <https://rbi.org.in/scripts/PublicationReportDetails.aspx?UrlPage=&ID=920>
9. Bank of Tanzania. “The Bank of Tanzania Act.” 2006. Available at: <https://www.bot.go.tz/BOTAct2006.pdf>
10. Bank of Tanzania. “Microfinance Act.” 2018. Available at: <https://tanzlii.org/akn/tz/act/2018/10/eng@2018-11-23>
11. “Evolution of Digital Lending in Fintech: India – UK Comparison.” 2023. Available at: [https://papers.ssrn.com/sol3/Delivery.cfm/SSRN\\_ID4558960\\_code5910975.pdf?abstractid=4558960&mirid=1&type=2](https://papers.ssrn.com/sol3/Delivery.cfm/SSRN_ID4558960_code5910975.pdf?abstractid=4558960&mirid=1&type=2)
12. Tanzania. “The electronic and postal communications act.” 2018. Available at: [https://www.tcra.go.tz/uploads/documents/sw-1619087013\\_The%20Electronic%20and%20Postal%20Communications%20\(Consumer%20Protection\)%20Regulations,%202018.pdf](https://www.tcra.go.tz/uploads/documents/sw-1619087013_The%20Electronic%20and%20Postal%20Communications%20(Consumer%20Protection)%20Regulations,%202018.pdf)
13. UNCDF. “Financial Inclusion Framework.” 2023. Available at: <https://policyaccelerator.uncdf.org/whats-new/tanzania-new-national-financial-inclusion-framework#:~:text=The%20NFIF%20sets%20out%20specific,their%20participation%20in%20economic%20activities.>
14. Bank of Tanzania. “Consumer Protection.” 2023. Available at: <https://www.bot.go.tz/DFDI/ConsumerProtection>
15. Bank of England. “New firm authorisation – supporting documents required for credit union applications.” 2024. Available at: <https://www.bankofengland.co.uk/-/media/boe/files/prudential-regulation/authorisations/new-firm-authorisation/new-firm-authorisation-supporting-documents-for-credit-union-applications.pdf>
16. United Kingdom, “Financial Services and Markets Act.” 2000. Available at: <https://www.legislation.gov.uk/ukpga/2000/8/contents>
17. Financial Conduct Authority. “Supporting material for applications by consumer credit, mortgage and other consumer finance firms” 2023. Available at: <https://www.fca.org.uk/firms/authorisation/supporting-material-credit-mortgage-consumer-finance>
18. United Kingdom. “Data Protection Act.” 2018. Available at: <https://www.legislation.gov.uk/ukpga/2018/12/contents>
19. EU. “General Data Protection Regulation.” 2018. Available at: <https://gdpr-info.eu/>
20. United Kingdom. “Financial Ombudsman Service.” 2024. Available at: <https://www.financial-ombudsman.org.uk/#:~:text=The%20Financial%20ombudsman%20Service%20is,power%20to%20put%20things%20right.>
21. Cambridge Centre for Alternative Finance. “The Future of Global Fintech: Towards Resilient and Inclusive Growth.” 2024. Available at: [https://www.jbs.cam.ac.uk/faculty-research/centres/alternative-finance/publications/the-future-of-global-fintech-towards-resilient-and-inclusive-growth#:~:text=Looking%20ahead%2C%20artificial%20intelligence%20\(AI,development%20in%20the%20near%20future.](https://www.jbs.cam.ac.uk/faculty-research/centres/alternative-finance/publications/the-future-of-global-fintech-towards-resilient-and-inclusive-growth#:~:text=Looking%20ahead%2C%20artificial%20intelligence%20(AI,development%20in%20the%20near%20future.)

- [20future.](#)
22. University of Cambridge. “The Global Covid-19 Fintech Market Rapid Assessment Study.” 2020. Available at:  
<https://www.jbs.cam.ac.uk/wp-content/uploads/2020/12/2020-ccaf-global-covid-fintech-market-rapid-assessment-study.pdf>
  23. Technoidentity. “Leadership insight: From Cyberspace to your pocket – Evolution of Digital Lending.” 2023. Available at:  
<https://www.technoidentity.com/insights/leadership-insight-from-cyberspace-to-your-pocket-evolution-of-digital-lending/>
  24. AFI. “Policy Framework for Responsible Digital Credit.” 2020. Available at:  
<https://www.afi-global.org/publications/policy-framework-for-responsible-digital-credit/>
  25. AFI. “Digital Credit Regulation in Tanzania.” 2020. Available at:  
<https://www.afi-global.org/publications/digital-credit-regulation-in-tanzania/>
  26. BIS. “FinTech credit: Market structure, business models and financial stability implications” 2017. Available at:  
[https://www.bis.org/publ/cqfs\\_fsb1.htm](https://www.bis.org/publ/cqfs_fsb1.htm)
  27. Australian Securities & Investments Commission. “Marketplace lending (peer-to-peer lending) products.” 2020. Available at:  
<https://asic.gov.au/regulatory-resources/financial-services/marketplace-lending/marketplace-lending-peer-to-peer-lending-products/#what-is>
  28. Lexology. “First-step analysis: fintech regulation in Germany.” 2023. Available at:  
<https://www.lexology.com/library/detail.aspx?g=d6203c94-3a00-49a9-9273-0aeab22af711#:~:text=The%20German%20Federal%20Financial%20Regulatory,of%20regulated%20activities%20or%20products.>
  29. HM Treasury. “Regulation of Buy-Now PayLater.” 2023. Available at:  
[https://assets.publishing.service.gov.uk/media/63ea41a9e90e077bbb30a4fc/BNPL\\_consultation\\_on\\_draft\\_legislation.pdf](https://assets.publishing.service.gov.uk/media/63ea41a9e90e077bbb30a4fc/BNPL_consultation_on_draft_legislation.pdf)
  30. Санхүүгийн зохицуулах хороо. “ББСБ-аас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын харьцаа тогтоох тухай” 2022. Эх үүсвэр:  
[http://www.frc.mn/resource/frc/Document/2022/10/14/d9euerxqn23vq0tf/20221014\\_527.pdf](http://www.frc.mn/resource/frc/Document/2022/10/14/d9euerxqn23vq0tf/20221014_527.pdf)
  31. Санхүүгийн зохицуулах хороо. “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам” 2022. Эх үүсвэр:  
[http://www.frc.mn/resource/frc/Document/2023/02/20/hknmnnv4lquo19mpa/frc\\_160-2023%20%D0%BD%D1%8D%D0%BC%D1%8D%D0%BB%D1%82%20%D3%A9%D3%A9%D1%80%D1%87%D0%BB%D3%A9%D0%BB%D1%82%D1%82%D1%8D%D0%B9.pdf](http://www.frc.mn/resource/frc/Document/2023/02/20/hknmnnv4lquo19mpa/frc_160-2023%20%D0%BD%D1%8D%D0%BC%D1%8D%D0%BB%D1%82%20%D3%A9%D3%A9%D1%80%D1%87%D0%BB%D3%A9%D0%BB%D1%82%D1%82%D1%8D%D0%B9.pdf)
  32. Санхүүгийн зохицуулах хороо. “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” 2020. Эх үүсвэр:  
<http://www.frc.mn/resource/frc/Document/2021/11/19/u92m056pixh8qsvf/998.pdf>
  33. Монгол улс. “Зээлийн мэдээллийн тухай.” 2011. Эх үүсвэр:  
<https://legalinfo.mn/mn/detail/9175>
  34. Санхүүгийн зохицуулах хороо. “Бүртгэлтэй финтек аппликэйшн.” 2024. Эх үүсвэр:  
<http://frc.mn/#/sct:id=12/doc/decree/998>
  35. Санхүүгийн зохицуулах хороо. “Санхүүгийн салбарын тойм 2023 он.” Эх үүсвэр:  
<http://frc.mn/resources/Images/Document/202403/n5zrJ/Urult-toim-2024.03.11.pdf>



ЗЭЭЛИЙН БАТЛАН  
ДААЛТЫН САН

## ОРОН НУТГИЙН ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТЛАН ДААЛТ




### Зорилго

- Улаанбаатар хотын хэт төвлөрлийг сааруулах
- Орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих
- Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх
- Урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй иргэдэд батлан даалт гаргах.

### Хамрах хүрээ

- Монгол Улсын 21 аймаг
- Налайх, Багануур, Багахангай дүүрэг



### Ипотекийн зээлийн батлан даалтын нөхцөл

- Зээлийн хүү: 6%
- Зээлийн хугацаа: 360 сар
- Зээлийн хэмжээ: 150 сая төгрөг хүртэл
- Батлан даалтын хувь: 60% хүртэл  
(Урьдчилгаа төлбөрийн)



Дэлгэрэнгүй мэдээллийг: 7700-2035

(2025 оны 7-р сарын 29-ний байдлаар)



## Батлан даалт хүсэгчид тавигдах ерөнхий шаардлага



- ✓ 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн;
- ✓ Орон сууцны ипотекийн зээл, эсвэл “түрээслээд өмчлөх” хөтөлбөрт хамрагдаж байгаагүй байх;
- ✓ Хамтран зээлдэгч нь ипотекийн хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэлгүй байх;
- ✓ Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өргүй байх;
- ✓ Өр төлбөр болон татварын үлдэгдэлгүй байх;
- ✓ 1 жилээс дээш тогтвор суурьшилтай ажилласан байх. Хувиараа бизнес эрхлэгч бол тухайн үйл ажиллагаагаа 2 ба түүнээс дээш жил эрхэлсэн байх;
- ✓ Сар бүрийн зээлийн эргэн төлөлт нь өрхийн татварын өмнөх орлогын 45 хувиас ихгүй байх;
- ✓ Батлан даалтын гэрээний хугацаанд эд хөрөнгө болон амь насны даатгалд бүрэн хамрагдах.

## Батлан даалтгад хамрагдах орон сууцанд тавигдах шаардлага



- ✓ Нийт талбайн хэмжээ 80 м<sup>2</sup>-аас бага байх
- ✓ Инженерийн дэд бүтцийн шийдэлтэй байх;
- ✓ Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байх;
- ✓ Эд хөрөнгө болон түүнтэй холбоотой эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх шаардах эрх үүсээгүй байх.

### Шимтгэл, хураамж

Шимтгэл:	Жил бүр батлан даалтын үлдэгдэл дүнгийн 1%
Үйлчилгээний хураамж:	10,000 төгрөг



Дэлгэрэнгүй мэдээллийг: 7700-2035

(2025 оны 7-р сарын 29-ний байдлаар)

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ


### ХЯТАД УЛС НҮҮРСНИЙ ЭКСПОРТОО НЭМЭГДҮҮЛЖ, ИМПОРТОО ХУМЬЖ БАЙНА .

2025 оны эхний таван сард Хятад улс нийт 2.5 сая тонн нүүрс экспортолсон нь 2024 оны мөн үетэй харьцуулахад 13%-иар өссөн үзүүлэлт болжээ. Хятадын нүүрсний гол худалдан авагчид нь Япон, Индонез, Өмнөд Солонгос зэрэг улсууд байна.

#### China's Coal Exports Rise

Top buyers saw more Chinese shipments except Japan

■ Jan-May 2025 ■ Jan-May 2024



Source: China's Customs Office

Экспортын нийт хэмжээ Хятадын жилийн дунджаар олборлодог 5 тэрбум тонн нүүрсгүй харьцуулахад харьцангуй бага боловч “гадаад экспорт нэмэгдэж, импорт буурч буй” үзэгдэл нь онцлог юм. Энэ нь зүүн Азийн зуны улиралд эрчим хүчний эрэлт нэмэгдэж, нүүрсний импорт өсдөг хандлагаас ялгаатай байна.

2024 онд Хятадын нүүрсний импорт 500 сая тонныг давсан нь дотоодын нийлүүлэлтийг дэмжсэн төрийн бодлого үр дүнгээ өгч, нүүрсний илүүдэл бий болсон. Үүний нөлөөгөөр дотоодын нүүрсний үнэ сүүлийн дөрвөн жилийн хамгийн доод түвшинд хүрч, импортын хэмжээ 8 хувиар буурсан байна.

Мөн Хятадын нүүрсний гол нийлүүлэгчдийн дундаас зөвхөн Австрали улс 5 дугаар сард нийлүүлэлтээ нэмэгдүүлсэн байна.

Эх сурвалж: [www.bloomberg.com](http://www.bloomberg.com)

### ДЭЛХИЙН БАНК: ХУДАЛДААНЫ ТОГТВОРГҮЙ БАЙДЛААС БОЛЖ ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ТӨЛӨВИЙГ БУУРУУЛЛАА.

Дэлхийн банк энэ сарын 10 өдөр дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг буурууллаа. Үүний шалтгааныг

худалдааны тодорхойгүй байдлаас үүдэлтэй хүндрэл гэж тайлбарлажээ.

2025 онд дэлхийн эдийн засаг 2.3% өснө гэж таамаглаж байгаа нь өмнөх 2.7%-ийн төсөөллөөс доогуур байна.

"Энэ нь 2008 оноос хойшхи дэлхийн эдийн засгийн хамгийн удаан өсөлт байх бөгөөд зөвхөн дэлхийн хямралын үед тохиолдож байсан удаашралуудаас бусад үед ийм сул өсөлт үзэгдээгүй" хэмээн Дэлхийн банкны "Дэлхийн эдийн засгийн төлөв байдал" тайланд дурджээ.

Худалдааны тодорхойгүй байдал ялангуяа ирээдүйн төлөвт хүндрэлтэй байгааг дэлхийн банк онцолсон байна.

АНУ-ын 2025 оны өсөлтийн таамаглалыг Дэлхийн банк 0.9 пунктээр бууруулж 1.4% болгосон бол Евро бүсийн өсөлтийн төлөвийг 0.3 пунктээр бууруулж 0.7% болгожээ.

Банкны үзэж буйгаар, хэрэв худалдааны хурцадмал байдал үргэлжлэн нэмэгдвэл өсөлт цаашид ч буурах эрсдэлтэй. Харин эсрэгээрээ, гол эдийн засгууд хоорондоо урт хугацааны худалдааны хэлэлцээр байгуулж чадвал байдал сайжирч болзошгүй.

"Манай дүн шинжилгээгээр, хэрэв өнөөгийн худалдааны маргаанууд шийдэгдэж, 2025 оны тавдугаар сарын эцсийн байдлаарх тарифын түвшнээс хагас болгон бууруулах гэрээнүүд байгуулвал, дэлхийн эдийн засгийн өсөлт 2025-2026 онуудад дунджаар 0.2 пунктээр нэмэгдэх боломжтой" хэмээн Гилл хэлжээ.

АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп дөрөвдүгээр сард олон оронд өндөр тариф ногдуулсны дараа АНУ болон түүний гол худалдааны түншүүд хэлэлцээрт орсон бөгөөд зарим татварыг түр хугацаагаар бууруулах тохиролцоонд хүрсний үндсэн дээр АНУ ба БНХАУ энэ долоо хоногт Лондонд уулзалт хийж байна.


Мөн АНУ ба Европын Холбооны хооронд ч хэлэлцээрүүд үргэлжилж байгаа бөгөөд өмнө нь зарласан тарифууд хүчин төгөлдөр болохоос өмнө ердөө нэг сар хүрэхгүй хугацаа үлдээд байна.

Дэлхийн банкны энэхүү өсөлтийн төсөөллийг бууруулсан явдал нь олон улсын бусад байгууллагуудын байр суурийг

дагасан үйлдэл юм. Тухайлбал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) мөн энэ сард худалдаа, тарифын тодорхойгүй байдал нь эдийн засгийн өсөлтийг удаашруулж байгаа гол шалтгаан хэмээн үзэж, 2025 оны дэлхийн өсөлтийн төсөөллөө 2.9% болгон бууруулсан байна. Тус байгууллага өмнө нь 2025 онд өсөлт 3.1% байна гэж таамаглаж байжээ.

*Эх сурвалж: www.cnn.com*

**АНУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ 6-Р САРД ХҮЛЭЭЛТЭЭС ДАВСАН 147,000 АЖЛЫН БАЙРЫГ ШИНЭЭР НЭМСЭН БӨГӨӨД АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН 4.1 ХУВЬ БОЛЖ БУУРСАН БАЙНА. ГЭХДЭЭ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ХАРВАЛ ЗАРИМ ТҮГШҮҮРТЭЙ ДОХИО ИЛЭРЧ БАЙНА.**



Ажлын байрны өсөлт салбар тус бүрд харьцангуй жигд бус байгаа нь ажлын байр нэмэгдэх боломж зөвхөн тодорхой хэдхэн салбарт төвлөрч байгааг харуулж байна.

6-р сард эрүүл мэндийн салбар (+58,600 ажлын байр), аялал жуулчлалын салбар (+20,000), мөн орон нутгийн болон муж улсын төрийн байгууллагад (+80,000) ажлын байр бий болжээ.

Төрийн байгууллагын өсөлтийг (80,000 ажлын байр) тусад нь авч үзвэл, холбооны түвшинд 7,000 ажлын байр хасагдсан тул нийт төрийн салбарын нэмэгдэл бага зэрэг тэнцвэржсэн. Ингэснээр хувийн хэвшлийн компаниуд 6-р сард ердөө 74,000 ажлын байр нэмжээ — энэ нь 2024 оны 10-р сараас хойших хамгийн бага өсөлт юм.

“Тарифын нэмэгдэл, мөнгөний хатуу бодлого, худалдааны дайн улам хурцдах вий гэсэн болгоомжлол зэрэг нь хөдөлмөрийн эрэлтийг хүнд байдалд оруулж байна” гэж Pantheon Macroeconomics-ийн АНУ-ын ахлах эдийн засагч Самуэль Томбс хөрөнгө оруулагчдад илгээсэн

тэмдэглэлдээ бичжээ. “Эрүүл мэнд, боловсролын салбарыг оролцуулахгүйгээр тооцвол хувийн хэвшлийн цалинтай ажлын байр ердөө 23,000-аар өссөн байна. Энэ нь сүүлийн 12 сарын дундаж болох 50,000-оос хавьгүй доогуур үзүүлэлт бөгөөд үндсэндээ энэ нь сул тайлан юм.”

Томбс мөн хөдөлмөрийн статистикийн газар (BLS)-ын улирлын хэлбэлзлийг жигд болгох зорилготой математик засварууд зарим тоог илүү өөдрөг харагдуулж болзошгүйг онцолжээ. Жишээлбэл, зуны улиралд боловсролын салбар дахь ажил багасах нь хэвийн үзэгдэл боловч энэ жил бууралт бага байсан нь статистикийн улирлын тохируулгаар “өсөлт” мэт туссан байж магадгүй юм.

Хөдөлмөрийн зах зээлд оролцож буй иргэдийн хувь (labor force participation rate) бага зэрэг буурсан бол хар арьстай ажилчдын ажилгүйдэл 0.8 пунктээр нэмэгдэж 6.8 хувь болж өссөн байна. Энэ нь 2022 оны 1-р сараас хойших хамгийн өндөр түвшин юм.

Ажлын байрны сар бүрийн тайланд суурь болдог хоёр үндсэн судалгааны нэг болох өрхийн судалгаа сард хэлбэлзэлтэй байдаг ч хар арьстнуудын ажилгүйдэл нэмэгдэх нь эдийн засгийн сулралын өмнөх дохио болж ирсэн түүхтэй.

“Эдийн засгийн өсөлт удаахрах үед хар арьст ажилчид илүү эмзэг бүлэгт тооцогдож, ажлын байрны баталгаагүй орчинд байж болох тул үр нөлөө хурдан мэдрэгддэг гэж үздэг. Гэвч энэ нь аль салбар хамгийн их өртөж байгаагаас хамаарч богино хугацаанд өөрчлөгддөг” хэмээн Glassdoor компанийн ахлах эдийн засагч Даниэл Жао CNN-д өгсөн ярилцлагадаа хэлжээ.

Ажилчдын цалин эдийн засагчдын хүлээлтээс бага өссөн байна. Цагийн дундаж цалин 8 цент буюу 0.2%-иар өсч, 36.30 ам.доллар болсон нь жилийн өсөлтийг 3.9%-аас 3.7% болгож бууруулжээ.

Ажилгүйдлийн түвшин 4.1 хувь болж буурсан ч энэ нь хөдөлмөрийн хүчний оролцоо буурсантай холбоотой байж болзошгүйг эдийн засагчид анхааруулж байна.

“Иммиграцийн хатуу бодлогын хуримтлагдсан үр нөлөө хөдөлмөрийн хүчний хэмжээ багасахад хүргэж, ингэснээр эдийн засгийн удаашралын үед ажилгүйдэл огцом өсөхгүй байх хязгаар үүсгэж магадгүй” хэмээн RSM US компанийн ахлах эдийн засагч Жо Брусуэлас пүрэв гарагт бичсэн тэмдэглэлдээ дурджээ.


*Эх сурвалж: www.cnn.com*

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2025 оны 07 дугаар сарын 30-ны өдөр


S&P 500 /<sup>^</sup>GSPC/

**6,362.90** -7.96 (-0.12%)




Nikkei 225 /<sup>^</sup>N225/

**40,972.41** +317.71 (+0.78%)



FTSE 100 /<sup>^</sup>FTSE/

**9,136.90** +0.62 (+0.01%)



NASDAQ Composite (<sup>^</sup>IXIC)

**21,129.67** +31.38 (+0.15%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia

